



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2025 оны I улирал



Цахим хувилбар



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2025 оны I улирал

Энэхүү тайланд тусгагдсан үр дүн, тайлбар, дүгнэлт нь Эдийн засаг, хөгжлийн яамны байр суурийг илэрхийлэх албагүй болно.

Уг тайланг арилжааны бус зорилгоор бүрэн болон хэсэгчилсэн байдлаар ашиглаж болох бөгөөд ашигласан тохиолдолд “Макро эдийн засгийн танилцуулга, 2025 оны 1 дүгээр улирал, Эдийн засаг, хөгжлийн яам” хэмээн эх сурвалж хэсэгт тодотгоно уу. Санал хүсэлт болон өөр бусад мэдээллийн талаар асууж тодруулах бол MEPD@med.gov.mn цахим шуудан эсвэл дараах хаягаар хандана уу.

Эдийн засаг, хөгжлийн яам, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр, Улаанбаатар хот 15141, Монгол Улс

ЭКСПОРТЫН БУУРАЛТ

2025 оны I улирал

Агуулга

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ	i
БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ	ii
1. БОДИТ СЕКТОР	1
1.1. Нийт нийлүүлэлт	2
1.2. Нийт эрэлт	5
1.3. Хөдөлмөр ба аж ахуйн нэгж	7
1.4. Эдийн засгийн мөчлөг	12
2. ТӨСВИЙН СЕКТОР	17
2.1. Төсвийн гүйцэтгэл	18
2.2. Төсвийн бодлогын төлөв	21
2.3. Засгийн газрын өрийн тогтвортой байдал	23
3. МӨНГӨНИЙ СЕКТОР	27
3.1. Инфляц	28
3.2. Мөнгө ба санхүүгийн салбар	32
4. ГАДААД СЕКТОР	37
4.1. Гадаад худалдаа	38
4.2. Төлбөрийн тэнцэл, гадаад өр	41
5. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ	46
5.1. Дэлхийн эдийн засаг	47
5.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага	48
5.3. Олон улсад зарлагдсан индексүүд	50
Хавсралт	54

Зураг, хүснэгт, шигтгээний жагсаалт

Зураг 1.1. Бодит ДНБ-ий өсөлт (нийлүүлэлт талаас).....	4
Зураг 1.2. Бодит ДНБ-ий өсөлт (эрэлт талаас)	6
Зураг 1.3. Хөдөлмөрийн зах зээл	7
Зураг 1.4. Аж ахуйн нэгж.....	10
Зураг 1.5. Хэрэглэгчийн итгэлийн индекс, улирлаар	11
Зураг 1.6. Үйлдвэрлэлийн зөрүү	12
Зураг 2.1. Төсвийн орлого	19
Зураг 2.2. Төсвийн зарлага	20
Зураг 2.3. Төсвийн тэнцэл, төсвийн төлөв, автомат тогтворжуулагч.....	22
Зураг 2.4. Засгийн газрын өр	23
Зураг 2.5. Засгийн газрын өрийн тогтвортой байдал.....	25
Зураг 3.1. Инфляцын бүрэлдэхүүн.....	28
Зураг 3.2. Тэйлорын хүү, мөнгөний нөхцөлийн индекс	29
Зураг 3.3. Голлох бүтээгдэхүүний үнэ	31
Зураг 3.4. Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үзүүлэлтүүд.....	32
Зураг 3.5. Хадгаламжийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн үзүүлэлтүүд.....	33
Зураг 4.1. Экспорт	38
Зураг 4.2. Импорт	40
Зураг 4.3. Урсгал болон санхүүгийн дансны тэнцэл, төгрөгийн ханш	41
Зураг 4.4. Урсгал данс, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад өр.....	43
Зураг 4.55. Гадаад өрийн тогтвортой байдал.....	44
Зураг 5.1. Дэлхийн тодорхой бус байдлын индекс	47
Зураг 5.2. Түүхий эдийн олон улсын зах зээл дэх үнэ.....	49
Зураг 5.33. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс.....	51
Хүснэгт 1. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тооны өөрчлөлт, ажиллагчдын тоогоор	9
Хүснэгт 2. Хэрэглэгчийн итгэлийн индексийн бүрэлдэхүүн.....	11
Хүснэгт 3. Санхүүгийн салбарын эмзэг байдал.....	35
Хүснэгт 4. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ.....	50
Хүснэгт 5. Хүний хөгжлийн индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ	53
Хүснэгт 6. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	55
Хүснэгт 7. Бодит секторын үзүүлэлтүүд	56
Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд.....	57
Хүснэгт 9. Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд.....	58
Хүснэгт 10. Мөнгөний үзүүлэлтүүд	59
Шигтгээ 1. Хэрэглэгчийн итгэлийн индекс.....	11

Товчилсон үг

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж, ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОУВС	Олон улсын валютын сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УЦС	Усан цахилгаан станц
ҮНО	Үндэсний нийт орлого
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХНХСҮСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ

Эдийн засгийн өсөлтийн хурд саарлаа. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сэргэж, үйлчилгээний салбарууд тэлсэн ч уул уурхай, тээвэр, барилга, худалдааны салбаруудын үйл ажиллагаа агшсанаар Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2025 оны эхний улиралд 2.4 хувьд хүрч удааширлаа. Эрэлт талаас эдийн засгийн өсөлтийг хөрөнгө оруулалт болон өрхийн хэрэглээний тэлэлт дэмжсэн ч экспорт болон төрийн хэрэглээний бууралт эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлээ. Ажиллах хүчний оролцооны түвшин 62 хувьд хүрч, нэрлэсэн орлого өссөн нь нийт өрхийн хэрэглээг дэмжсэн ч үнийн өсөлтийн нөлөөгөөр өрхийн бодит орлогын өсөлт саарлаа. Эдийн засгийн нийт үйлдвэрлэл потенциал түвшнээсээ 0.6 орчим хувиар доогуур байна.

Экспортын орлого буурч, урсгал дансны алдагдал нэмэгдлээ. Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр зэрэг голлох уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагдсан хэдий ч нүүрсний үнийн бууралтын голлох нөлөөгөөр экспортын орлого буурлаа. Хэдийгээр нийт импортын өсөлт саарсан ч экспорт буурснаар урсгал дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 1.8 дахин тэллээ. Гадаад валютын нөөц 2025 оны эхний улирлын эцэст 5.0 тэрбум ам.долларт хадгалагдсан ч төв банкны зах зээлд нийлүүлсэн гадаад валютын хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.7 тэрбум ам.доллаар өсөж, төгрөгийн ам.долларт харьцах ханш оны эхнээс 2 хувиар суларлаа.

Нүүрсний экспортын орлого буурч, төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөсөн дүнгээс доогуур байна. Нэгдсэн төсвийн орлого 2025 оны эхний улирлын байдлаар 6.1 их наяд төгрөгт болж, өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд төгрөгөөр буурав. Нүүрсний хилийн дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 39.9 хувиар, экспортын тоо хэмжээ 3.3 хувиар буурсан нь төсвийн голлох орлогуудад сөргөөр нөлөөлсөн байна. Төсвийн нийт зарлага 6.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 14.2 хувиар тэлэхэд урсгал зарлагын өсөлт, тэр дундаа төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Инфляц төв банкны зорилтот түвшнээс өндөр хадгалагдав. Инфляц 2025 оны эхний улиралд төв банкны зорилтот түвшнээс өндөр хадгалагдаж, улирлын эцэст 9.1 хувьд хүрлээ. Гадаад валютын орлогын бууралтаас үүдэлтэйгээр мөнгөний нийлүүлэлтийн хурд саарсан хэдий ч дотоод зээлийн өсөлт өндөр хэвээр хадгалагдлаа. Төв банкнаас мөнгөний бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэлээ.

БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ

Эдийн засгийн өсөлт 2025 онд 5.5 орчим хувь байхаар тооцоолж байна. Салбаруудаар авч үзвэл, хөдөө аж ахуй, боловсруулах салбаруудын үйлдвэрлэл сэргэж, үйлчилгээний салбаруудын үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж, эдийн засгийн өсөлтийг дэмжих төлөвтэй байна. Тухайлбал, байгаль цаг уурын нөхцөл байдал өмнөх жилүүдтэй харьцуулахад таатай байх нөлөөгөөр төл бойжилт өндөр, том малын зүй бус хорогдол бага байж, хөдөө аж ахуй, боловсруулах салбарууд эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлөх төлөвтэй байна. Мөн уул уурхайн салбарт Оюу толгойн баяжмал дахь зэс, алтны агуулга өсөхөөр байгаа нь салбарын өсөлтөд томоохон нөлөөг үзүүлэхээр байна. Эрэлт талаас хөрөнгө оруулалт болон өрхийн хэрэглээ эдийн засгийн өсөлтийг үргэлжлүүлэн

дэмжих хүлээлттэй байна. Мал аж ахуйн салбарт эх малын тоо, төл бойжилт нэмэгдэх нөлөөгөөр нийт хөрөнгийн хуримтлал өсөж, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх төлөвтэй байна.

Инфляц 2025 онд дунджаар төв банкны зорилтот түвшнээс өндөр байх хүлээлттэй байна. Жил дараалсан хөдөө аж ахуйн салбарын агшилтаас үүдэлтэйгээр махны нийлүүлэлт буурч, махны үнэ улирлын хандлагаасаа өндрөөр өсөх, цахилгааны тарифын нэмэгдлийн нөлөөгөөр дотоодын бараа, үйлчилгээний инфляц өсөх төлөвтэй байна. Цаашид геополитикийн тогтворгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, тээвэр логиستيкийн саатлаас үүдэн импортын инфляц нэмэгдэх эрсдэлүүд хэвээр байна.

Бүлэг 1

БОДИТ СЕКТОР

- 1.1. Нийт нийлүүлэлт
- 1.2. Нийт эрэлт
- 1.3. Хөдөлмөр ба аж ахуйн нэгж
- 1.4. Эдийн засгийн мөчлөг

1. БОДИТ СЕКТОР

ТОЙМ

Эдийн засгийн өсөлт 2025 оны эхний улиралд 2.4 хувьд хүрч удааширлаа. Хэдийгээр хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сэргэж, үйлчилгээний салбарууд өссөн ч уул уурхай, түүнийг дагасан тээвэр болон барилга, худалдааны салбар агшиж, нийт эдийн засгийн өсөлтийг сааруулав. Эрэлт талаас хөрөнгө оруулалт, өрхийн хэрэглээ эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол барааны экспорт, төрийн хэрэглээ буурсан нь өсөлтийг саарууллаа. Ажиллах хүчний оролцооны түвшин 62 хувьд хүрч, нэрлэсэн орлого өссөн нь нийт өрхийн хэрэглээг дэмжсэн ч үнийн өсөлтийн нөлөөгөөр өрхийн бодит орлогын өсөлт 5.8 хувьд хүрч саарлаа. Эдийн засгийн потенциал өсөлт 5 хувьд хүрч нэмэгдсэнээр үйлдвэрлэлийн зөрүү сөрөг 0.6 хувь боллоо.

1.1. Нийт нийлүүлэлт

1. Эдийн засгийн өсөлт 2.4 хувьд хүрч удааширлаа. ДНБ 2025 оны эхний улиралд нэрлэсэн дүнгээр 19 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 15 хувиар, бодит дүнгээр 6.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн өсөлт өмнөх оны мөн үеийн 7.9 хувиас 5.5 нэгж хувиар саарч, төсөөллөөс доогуур гарлаа. Үйлчилгээний салбарууд болон хөдөө аж ахуйн салбарын сэргэлт эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол уул уурхайн салбарын өсөлт удааширч, тээвэр, худалдаа, барилга, цэвэр татвар зэрэг салбарууд агшиж, өсөлтийг сааруулав.

2. Уул уурхайн салбарын өсөлт удааширч, 0.8 хувиар өслөө. Уул уурхайн салбар өмнөх оны мөн үед 13 хувиар өсөж байсан бол 2025 оны эхний улиралд зэсийн баяжмал үйлдвэрлэлээс бусад уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурснаар тус салбарын өсөлт 0.8 хувьд хязгаарлагдав. Оюу толгойн уурхайн нөлөөгөөр зэсийн баяжмал үйлдвэрлэл эрчимжиж, 2025 оны эхний улиралд 29 хувиар өссөнөөр 448 мянган тоннд хүрэв. Харин нүүрс олборлолт 20.4 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувиар буурсны зэрэгцээ төмрийн хүдэр, баяжмал үйлдвэрлэл 1.4 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 хувиар бага байв. Түүнчлэн, 2025 оны эхний улиралд газрын тос олборлолт 5 улирал, алтны олборлолт 9 улирал дараалан буурч, тус тус 1.0 сая тонн болон 1.8 тоннд хүрээд байна.

3. Уул уурхайн бус салбарын өсөлт мөн саарав. Уул уурхайн бус салбар 2024 оны эхний улиралд 7.0 хувиар өсөж байсан бол 2025 оны эхний улиралд 2.3 хувиар өсөөд байна. Уул уурхайн бус салбарын өсөлт саарахад тээврийн салбарын уналт гол нөлөөлсөн бөгөөд тээврээс

бусад уул уурхайн бус салбарын өсөлт 4.3 хувь байна.

Үйлчилгээний салбар 2025 оны эхний улиралд 2.2 хувиар тэллээ. Худалдааны салбарын борлуулалт буурч, тээврийн салбарын үйлдвэрлэл агшсан нь нийт үйлчилгээний салбарын өсөлт саарахад голлон нөлөөлөв.

Бөөний болон жижиглэн худалдааны салбар 2025 оны эхний улиралд 5.8 хувиар агшиж, нийт эдийн засгийн өсөлтийг 0.6 нэгж хувиар саарууллаа. Худалдааны салбарын нэрлэсэн дүнгээрх борлуулалтын орлогын өсөлт 0.4 хувьд хязгаарлагдаж, үнийн өсөлт өндөр хадгалагдсан нь тус салбарын уналтад нөлөөллөө. Хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа, тэр дундаа төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа буурч, өрхийн удаан эдэлгээт бараа бүтээгдэхүүний хэрэглээ саарсан нь салбарын нийт борлуулалтад сөрөг нөлөө үзүүлжээ. 2025 оны эхний улиралд худалдааны салбарт шинээр олгосон зээл, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо болон хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн хэдий ч дотоодын худалдаа эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг илэрхийлэх худалдан авалтын менежерийн индекс сөрөг төлөвт шилжиж, шинэ захиалга, үйлдвэрлэл, хүлээгдэж буй борлуулалт агших төлөвт гарсан нь салбарын хүлээлт сул байгааг илтгэж байна¹.

Харин мэдээлэл, холбооны салбарын өсөлт өндөр түвшинд хадгалагдаж, 16.5 хувиар тэлснээр нийт өсөлтөд 0.6 нэгж хувийн эерэг хувь нэмэр оруулав. Түүнчлэн, үйлчилгээний бусад салбарын үйл ажиллагаа хэвийн байж, энэ оны эхний улиралд өсөлт нь 7.1 хувьд хадгалагдлаа. Үйлчилгээний салбарын худалдан авалтын менежерийн индекс тэлэлтийн төлөвт гарч, эерэг хүлээлтээ хадгалж байна.

¹ Эх сурвалж: Худалдан авалтын менежерийн индекс - PMI, 2025 оны 1 дүгээр улирал. Монголбанк.

4. Тээврийн салбар огцом агшиж, төсөөллөөс доогуур үзүүлэлттэй гарав. Авто замын тээврийн орлого 2025 оны эхний улиралд буурсны улмаас тээврийн салбар 21.6 хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг 1.2 нэгж хувиар сааруулав. Тухайлбал, нүүрс тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн орлого буурсантай холбоотойгоор авто замын тээврийн орлого 1.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 32 хувиар, төмөр замын тээврийн орлого 373 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1 хувиар тус тус буурсан байна. Нийт ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеийн түвшнээс 1 хувиар бага гарсан, мөн тээврийн өртөг буурсантай холбоотойгоор орлого буурч, салбарын уналтад нөлөөллөө. Тухайлбал, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, тээврийн өртгийг бууруулахад чиглэсэн төмөр замын суурь бүтэц ашиглалтын тарифыг 50 хүртэлх хувиар хөнгөлөх, мөн авто тээврийн тарифыг бууруулах шийдвэрүүд тээврийн өртөг буурахад нөлөөллөө. Улмаар тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2025 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар, үүнээс хуурай замын (авто зам, төмөр зам) тээврийн дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 1.7 хувиар буурсан байна.

5. Боловсруулах салбарын өсөлт алгуур сэргэж байгаа ч төсөөллөөс доогуур байна. Зэсийн баяжмал зэрэг металлын хүдэр олборлох үйл ажиллагааны идэвхийг дагасан тэсэрч, дэлбэрэх химийн бодисын үйлдвэрлэлийн өсөлтийн голлох нөлөөгөөр боловсруулах салбар өмнөх оноос 3.7 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийг 0.2 нэгж хувиар дэмжлээ. Түүнчлэн, тамхи, нэхмэл, төмөрлөг бус эрдэс бодисын үйлдвэрлэл салбарын өсөлтөд эерэг нөлөө үзүүллээ. Харин мах, гурил зэрэг боловсруулах салбарын 35 орчим хувийг бүрдүүлдэг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэл боловсруулах салбарын өсөлтийг хязгаарлах нөлөө үзүүлсэн хэвээр байна.

6. Барилгын салбар агшлаа. Өмнөх оны эхний улиралд “Тосон” ДЦС, “Бөөрөлжүүт” ДЦС зэрэг эрчим хүчний барилга байгууламж, Өмнөговь аймаг дах төмөр замын бүтээн байгуулалт зэрэг томоохон бүтээн байгуулалтууд хийгдсэн суурийн голлох нөлөөгөөр барилгын салбар 2025 оны эхний улиралд 1.1 хувиар агшиж, нийт эдийн засгийн өсөлтийг 0.01 нэгж хувиар хязгаарлалаа. Харин орон нутаг дах орон сууцны барилгын бүтээн байгуулалтын ажил эрчимжсэн нь барилгын салбарын үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүллээ.

7. Эрчим хүчний салбарын өсөлт тогтвортой хадгалагдаж байна. Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбар 2025 оны эхний улиралд 5.5 хувиар өслөө. Тухайлбал, нийт 2,660 сая кВт.ц (үүнээс цахилгаан эрчим хүч 2,437 сая кВт.ц, сэргээгдэх эрчим хүч 223сая кВт.ц) эрчим хүч үйлдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар нэмэгдсэн бөгөөд дулааны эрчим хүч үйлдвэрлэл мөн өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өсжээ.


8. Мал аж ахуйн салбарын сэргэлтийн голлох нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбарын өсөлт 36 хувьд хүрч нэмэгдлээ. Хөдөө аж ахуйн салбар зудын хүндрэлийн нөлөөгөөр өнгөрсөн оны мөн үед 25 хувиар агшиж байсан бол 2025 оны эхний улиралд хаваржилт тогтуун байж, мал төллөлт, бойжилт хэвийн үргэлжилсний үр дүнд бойжсон төлийн тоо толгой 4.6 саяд хүрч (төл бойжилт 98.7 хувь) өмнөх оноос 1.3 сая толгой малаар нэмэгдэн, том малын зүй бус хорогдол 83.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 6.2 сая толгой малаар буурсны голлох нөлөөгөөр 36 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийг 1.0 нэгж хувиар дэмжлээ.

9. Бүтээгдэхүүний цэвэр татвар буурч, өсөлтийг хязгаарлалаа. Цэвэр татвар 2025 оны эхний улиралд 2.3 хувиар буурч, эдийн засгийн өсөлтийг 0.4 нэгж хувиар сааруулав. Дотоодын бараа, үйлчилгээний болон импортын барааны НӨАТ-ын орлого тус тус 5 хувь болон 8 хувиар нэмэгдсэн хэдий ч НӨАТ-ын буцаан олголт 2.1 дахин нэмэгдсэнээр нийт нэмэгдсэн өртгийн

албан татварын орлого буурч, цэвэр татварт сөргөөр нөлөөллөө.

Зураг 1.1. Бодит ДНБ-ий өсөлт (нийлүүлэлт талаас)


1.Эдийн засгийн өсөлт дэх салбаруудын оролцоо
(нэгж хувь)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт дэх салбаруудын оруулах хувь нэмрийг харуулав.


2.Салбаруудын бодит өсөлт
(хувь)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Салбаруудын бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлтийн хувийг харуулав.

3.Хөдөө аж ахуй
(мянган толгой мал)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Төл бойжилт, том малын зүй бус хорогдлын хэмжээг харуулав.

1.2. Нийт эрэлт

10. Хөрөнгө оруулалт болон өрхийн хэрэглээ өсөлтийг дэмжсэн бол барааны экспорт, төрийн хэрэглээний бууралт сааруулаа. Том малын зүй бус хорогдол өмнөх оны мөн үеэс буурсны голлох нөлөөгөөр үндсэн хөрөнгийн хуримтлал эдийн засгийн өсөлтөд эерэг хувь нэмэр орууллаа. Хөдөлмөр шингээлт ихтэй хөдөө аж ахуйн салбар сэргэн, хөдөлмөр эрхлэлт өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар нэмэгдэн, цалин хөлс үргэлжлэн өссөн нь өрхийн орлогод эерэг нөлөө үзүүлж, өрхийн хэрэглээ бодит дүнгээр тэлж, эдийн засгийн өсөлтийн 9.6 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Харин барааны экспорт буурснаар цэвэр экспорт эдийн засгийн өсөлтийг сааруулаа. Мөн төрийн хэрэглээ бодит дүнгээр хумигдаж, нийт өсөлтийг бууруулсан байна.

11. Малын зүй бус хорогдол буурч, биологийн өсөж үрждэг хөрөнгө 1.2 их наяд төгрөгөөр өссөнөөр хөрөнгийн хуримтлал нэмэгдлээ. Хөрөнгийн хуримтлалд эдийн засаг дах үндсэн болон эргэлтийн хөрөнгийн өсөлт, бууралтыг бүртгэдэг. Том малын зүй бус хорогдол өмнөх оны мөн үеэс 6.2 сая толгой малаар буурсны голлох нөлөөгөөр үндсэн хөрөнгийн хуримтлал 30.4 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтөд 9.9 нэгж хувийн эерэг хувь нэмэр орууллаа. Харин уул уурхайн үйлдвэрлэл удааширсны нөлөөгөөр эргэлтийн хөрөнгийн хуримтлал бодит дүнгээр 7.8 хувиар буурсан байна.

12. Өрхийн хэрэглээний өсөлтөд хүнсний хэрэглээний өсөлт голлож байна. Өрхийн хэрэглээ бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 9.6 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Өрхийн хүнсний хэрэглээний өсөлт 2025 оны эхний улиралд 16.1 хувьд хүрч, сүүлийн 7 жилийн хамгийн өндөр түвшинд хүрлээ. Өрхийн хүнсний зардлын өсөлтөд гурил, гурилан бүтээгдэхүүн, сүүн бүтээгдэхүүн болон согтууруулах ундаа, тамхинд зарцуулсан зардал голлох нөлөө үзүүлсэн байна. Харин цар тахлын дараа тавилга, цахилгаан

бараа зэрэг удаан эдэлгээт бараа бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэж, өнгөрсөн 2 жилийн турш тогтвортой 20 орчим хувиар өсөж ирсэн бол 2025 оны эхний улиралд өсөлтийн хурд саарч, 9.9 хувь болжээ. Түүнчлэн өрхийн аялал, амралттай холбоотой зардлууд буурсан бол тээврийн хэрэгсэл болон тээврийн үйлчилгээний зарцуулалт өсөлттэй хэвээр байна.

13. Өрхийн бодит орлогын өсөлт үргэлжлэн саарлаа. Үнийн өсөлтийн нөлөөг арилгасан өрхийн бодит орлого 2025 оны эхний улирлын байдлаар 5.8 хувиар өссөн нь өмнөх улирлаас 0.1 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 11.8 нэгж хувиар доогуур байна. Үүнд инфляц төв банкны зорилтот түвшнийг давсан болон өмнөх оны мөн үед эрчимтэй нэмэгдсэн өрхийн орлогын өсөлтийн суурь нөлөөлсөн байна. Харин нэрлэсэн орлого улсын дунджаар 2.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 394 мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 176 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Өрхийн бодит орлогын өсөлтөд цалингийн орлогын өсөлт 3.1 нэгж хувийг бүрдүүлж, голлох нөлөөг үзүүлсэн хэвээр байна. Төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх, орон нутагт ажиллаж буй албан хаагчдын цалин, урамшууллыг нэмэгдүүлэх бодлогын үр дүнд төрийн байгууллагуудын дундаж цалин 2023 онд 30.9 хувиар, 2024 онд 33.3 хувиар тус тус өссөн бол уг өсөлтийг даган хувийн секторын дундаж цалин 2023 онд 22.5 хувь, 2024 онд 22.7 хувиар тус тус нэмэгдсэн байна.


14. Хөдөөгийн өрхийн орлого улсын дунджаас өндрөөр өслөө. Монгол Улсад 2024 оны байдлаар бүртгэлтэй нийт 997 мянган өрх байгаагаас 306 мянган өрх нь хөдөөд амьдарч байна. 2025 оны эхний улирлын байдлаар нийслэлийн өрхүүдийн нэрлэсэн дундаж орлого 3.3 сая төгрөгт хүрч, бодит дүнгээр 4.8 хувиар өссөн бол сумын төвийн өрхүүдийнх 2.4 сая төгрөг болж, бодитоор 15.9 хувиар, хөдөөгийн өрхүүдийн нэрлэсэн орлого 2.2 сая төгрөг болж,

бодитоор 10.3 хувиар буюу улсын дунджаас илүү өндрөөр өсөж, байршлын хувьд орлогын зөрүү буурсан байна. Үүнд 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хөдөө суманд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг үндсэн цалингийн 40 хувиар тооцож нэмэгдүүлсэн нь голлох нөлөөг үзүүлжээ. Нөгөөтээгүүр мал, мах, ноолуур зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ 2025 оны эхний улиралд өмнөх оны түвшнээс өндөр байсан нь малчин өрхийн хөдөө аж ахуйн орлогыг 107.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх зэрэг нөлөө үзүүлсэн байна.

15. Барааны экспорт буурснаар цэвэр экспорт нийт өсөлтийг бууруулах нөлөө үзүүлээ. Цэвэр экспорт нь бараа, үйлчилгээний экспортын орлого болон бараа, үйлчилгээний импортын зардлын зөрүүгээр илэрхийлэгддэг. Бараа, үйлчилгээний импортын өсөлт 2025 оны эхний улиралд 2.9 хувьд хүрч саарав. Харин нүүрс, алт, газрын тос зэрэг экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн экспорт буурснаар барааны экспортын орлого 23.6 хувиар агшиж, өмнөх оны эхний улиралд ашигтай гарсан цэвэр экспорт энэ оны эхний улиралд нэрлэсэн дүнгээр 1.9 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, нийт эдийн засгийн өсөлтийг 14.9 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлэв.

Зураг 1.2. Бодит ДНБ-ий өсөлт (эрэлт талаас)


1. Эдийн засгийн өсөлт
(нэгж хувь)



2. Өрхийн бодит орлогын өсөлт
(нэгж хувь)



3. Үндсэн хөрөнгийн өсөлт
(нэгж хувь)



1.3. Хөдөлмөр ба аж ахуйн нэгж

16. Хөдөө аж ахуйн салбарын өсөлт нийт ажилчдын тооны өсөлтийг дэмжлээ. 2025 оны 1 дүгээр улиралд ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 48 мянгаар нэмэгдэж 1 сая 380 мянгад хүрлээ. Ажилчдын тоог улирлын нөлөөг² арилган тооцвол өмнөх оны мөн үеэс 57 мянгаар нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд нийт ажилчдын дөрөвний нэгийг бүрдүүлдэг хөдөө аж ахуйн салбарын ажилчдын тоо сэргэж өмнөх оны мөн үеэс 37 мянгаар буюу 11 хувиар өссөн нь голчлон нөлөөллөө. Мөн боловсруулах салбарт 21 мянга, тээврийн салбарт 14 мянган ажилчид нэмэгдсэн нь өсөлтийг дэмжлээ. Харин үйлчилгээний салбарын ажилчид 23 мянгаар, барилгын салбар 3 мянгаар, уул уурхайн салбарын ажилчдын тоо 2 мянгаар буурсан нь өсөлтийн хурдыг саарууллаа.


Байршлаар авч үзвэл, ажилчдын тоо Улаанбаатар хотод өмнөх оны мөн үеэс 37 мянгаар өсөж 641 мянга, хөдөөд 11 мянгаар нэмэгдэж 739 мянга болсон байна. Тодруулбал, ажилчдын тоо Төвийн бүсэд 11 мянга, Баруун бүсэд 4 мянгаар тус тус өссөн байна. Харин Хангайн бүсэд 2 мянгаар, Зүүн бүсэд 2 мянгаар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

17. Ажиллах хүчний оролцооны түвшин нэмэгдлээ. Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 55 мянгаар буюу 4 хувиар нэмэгдэж 1 сая 459 мянгад хүрснээр ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж өсөж 62 хувьд хүрэв. Энэ нь 1 дүгээр улирлын хувьд сүүлийн 13 жилийн ажиллах хүчний оролцооны хамгийн өндөр түвшин болж байна.

Ажиллах хүчний өсөлтийн дийлэнх хэсгийг ажилчдын тооны өсөлт тайлбарлаж байгаа бол нөгөө талаас ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 7 мянгаар өссөн нь нөлөөлсөн байна. Ажилгүй иргэдийн тоо ийнхүү өсөж 79 мянгад хүрснээр ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар нэмэгдэж 5.4 хувьд хүрсэн байна. Ажилгүй иргэдийн тооны өсөлтийг шалтгаанаар харвал, жирэмсэн, хүүхэд асарсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.2 мянгаар, тэтгэвэрт гарсан 1.9 мянгаар, ажил хайгаад олдохгүй байгаа 1.6 мянгаар нэмэгдсэн бол улирлын чанартай ажил хийдэг иргэд 1.6 мянгаар буурсан байна.

18. Хөдөлмөр эрхлэх сонирхолтой ч боломжгүй байсан иргэдийн тоо буурлаа. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо өмнөх оны мөн үетэй ижил

Зураг 1.3. Хөдөлмөрийн зах зээл



² Улирлын нөлөөг арилгах гэдэг нь хугацаан цувааны өгөгдөл дэх улирлын тогтмол хэв шинжүүдийг арилгах статистикийн арга юм. Эдгээр хэв шинжүүд нь цаг агаарын өөрчлөлт, баяр ёслол, сургууль, цэцэрлэгийн хуваарь, хөдөө аж ахуйн цикл гэх мэт янз

бүрийн хүчин зүйлсээс шалтгаалж бий болдог. Энэхүү тогтмол хэлбэлзлийг арилгаснаар өгөгдөл дэх бодит чиг хандлага, мөчлөгийн хөдөлгөөнүүдийг ажиглахад хялбар болгодог бөгөөд өөр өөр хугацааны мэдээллийг хооронд нь харьцуулах боломжийг олгодог.

буюу 893 мянга байсан ч жирэмсэн, хүүхэд асарсан, суралцдаг, сурахаар явж байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 33 мянгаар нэмэгдсэн бол ажил хайгаад олдохгүй байгаа, мэргэжил, дадлага туршлага байхгүй иргэд 8 мянгаар, өвчтөн, өндөр настан асардаг, малчин, тэтгэвэрт гарсан, өндөр настан иргэд 6-7 мянгаар буурсан байна.

Боломжит ажиллах хүч буюу хөдөлмөр эрхлэх сонирхолтой ч боломжгүй байсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 7 мянгаар буюу 19 хувиар буурч 29 мянгад хүрсэн байна. Түүнчлэн хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 0.8 нэгж хувиар буурч 7.4 хувьд хүрсэн нь иргэдийн хөдөлмөрийн зах зээл дэх идэвх нэмэгдэж ажиллах хүчний оролцоо сайжирч байгааг илтгэж байна.

19. Уул уурхайгаас бусад салбарт дундаж цалингийн хэмжээ өслөө. 2025 оны 1 дүгээр улиралд дундаж цалин өмнөх оны мөн үеэс 338 мянгаар өсөж 2 сая 262 мянган төгрөг, голч цалин өмнөх оны мөн үеэс 447 мянган төгрөгөөр өсөж 2 сая 245 мянган төгрөгт хүрсэн байна. Харин бодит цалин 1 сая 551 мянган төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 120 мянган төгрөгөөр өслөө.

Салбараар авч үзвэл, цахилгаан, усны салбарын ажилчдын дундаж цалин хамгийн өндөр өсөлттэй байж, 1 сая 709 мянган төгрөгөөр буюу 74 хувиар нэмэгдэж 4 сая 29 мянган төгрөгт хүрчээ. Ингэснээр уг салбар уул уурхайн салбарын дараа орох хоёр дахь хамгийн өндөр цалинтай салбар болж байна. Харин уул уурхайн салбарын дундаж цалин нүүрсний хилийн үнэ болон экспортын хэмжээ буурч, салбарын өсөлт удааширсны нөлөөгөөр өмнөх оны мөн үеэс 716 мянган төгрөгөөр буюу 13 хувиар буурч 4 сая 935 мянган төгрөг (улсын дунджаас 1.9 дахин өндөр)-т хүрсэн байна. Ингэснээр сүүлийн 3 жил дараалж өссөн уул уурхайн салбарын цалингийн хэмжээ буураад байна.

20. Хөдөлмөрийн бүтээмж буурав. Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин өмнөх оны

мөн үеэс 54.5 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурч 4 сая 260 мянган төгрөгт хүрлээ. Салбараар авч үзвэл, уул уурхайн салбарын бүтээмж өмнөх оны мөн үеэс 383 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар өсөж 11 сая 432 мянган төгрөгт хүрсэн нь хөдөлмөрийн бүтээмжийн улсын дундаж түвшнээс ойролцоогоор 3 дахин өндөр байна. Хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарын бүтээмжийн түвшин өмнөх оны мөн үеэс харгалзан 113 мянган төгрөг, 110 мянган төгрөгөөр өсөж 619.6 мянга, 4 сая 407 мянган төгрөгт хүрлээ. Харин аж үйлдвэр, барилгын салбарын бүтээмжийн түвшин 92.3 мянган төгрөгөөр буюу 3 хувиар буурч 2 сая 976 мянга төгрөг болсон байна. Үүнд тээвэр, боловсруулах салбарын бүтээмж буурсан нь голчлон нөлөөлжээ.

21. Шинээр байгуулагдсан ААН-ийн тоо нэмэгдлээ. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 266.1 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 25.2 мянгаар буюу 10.5 хувиар нэмэгдлээ. Уг өсөлтийн 18.3 мянгыг үйл ажиллагаа эхлээгүй буюу шинээр байгуулагдсан ААН-үүд бүрдүүлсэн бол 7.9 мянгыг үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд бүрдүүлээ. Үйл ажиллагаа явуулж буй болон шинээр байгуулагдсан ААН-ийн тоо нэмэгдсэн нь бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж байгааг илтгэж байна (Зураг 1.4).

22. Худалдаа, үйлчилгээний салбарын ААН-ийн тоо хамгийн ихээр нэмэгдэв. Салбараар харвал, худалдаа, үйлчилгээний салбарт шинээр байгуулагдсан ААН 10.2 мянгаар, үйл ажиллагаа явуулж буй ААН 4.6 мянгаар нэмэгдсэн нь ААН-ийн тооны өсөлтийн гол хэсгийг бүрдүүлж байна. Тус салбарт шинээр байгуулагдсан ААН-ийн тоо тухайн улирлын сүүлийн 10 жилийн дундаж болох 11.3 хувийн өсөлтөөс 26.3 хувиар давж өсжээ. Тодруулбал, бүх төрлийн барааны бөөний болон жижиглэнгийн худалдааны ААН-үүд, тэр дундаа хөдөө аж ахуйн түүхий эд, мал, амьтны болон хүнс, ундаа, тамхины худалдаа эрхэлдэг ААН-үүд нэмэгджээ. Гэхдээ худалдаа,

үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 2025 оны 1 дүгээр улиралд 6 хувиар өссөн нь тухайн улирлын сүүлийн 10 жилийн дундаж болох 7.4 хувийн өсөлтөд хүрэхгүй байна. Үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн хувьд гишүүнчлэл бүхий байгууллага, эмнэлэг, үйлдвэрчний эвлэл, сургалтын төв, бизнесийн зөвлөх үйлчилгээ, спорт, компьютер програмчлалын үйлчилгээ эрхэлдэг ААН-ийн тоо нэмэгдсэн байна.

23. Шинэ хоршоо хөдөлгөөний нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбар дахь хоршоодын тоо нэмэгдэв. Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолоор хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотойгоор 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж буй хоршооны тоо 2.6 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Хоршооны өсөлтийн нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбарын ААН-ийн тоо үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн хувьд тухайн улирлын сүүлийн 10 жилийн дундаж өсөлт болох 3.0 хувиас 46.3 хувиар, шинээр байгуулагдсан ААН-ийн хувьд тухайн улирлын сүүлийн 10 жилийн дундаж өсөлт болох 11.2 хувиас 266.5 хувиар илүү өсөлттэй гарлаа. Задалж харвал мал, амьтан өсгөх, үржүүлэх аж ахуйн үйл ажиллагаа, хөдөө аж ахуй болон ургац хураалтын дараах шатны үйл ажиллагааг дэмжсэн туслах үйл ажиллагаа, нэг наст ургамлын тариалалт, холимог фермерийн аж ахуй эрхэлдэг ААН-үүд нэмэгджээ.

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн тоо уул уурхайн салбарт 30, тээврийн салбарт 444 ААН-ээр нэмэгдсэн бол шинээр байгуулагдсан ААН-ийн тоо уул уурхайн салбарт 109, тээврийн салбарт 926 ААН-ээр нэмэгджээ. Экспортын өсөлт удааширсантай холбоотойгоор уул уурхай, тээврийн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тооны өсөлт нь өмнөх онуудын дундаж өсөлтөд хүрэхгүй байна. Тодруулбал, уул уурхайн салбарт үйл ажиллагаа

явуулж буй ААН-ийн тоо 2.5 хувиар нэмэгдсэн нь тухайн улирлын сүүлийн 10 жилийн дундаж өсөлтөөс 4.5 хувиар бага байна. Мөн тээврийн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 12.2 хувиар нэмэгдсэн нь тухайн улирлын сүүлийн 10 жилийн дундаж өсөлтөөс 6.0 хувиар бага байна.

24. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч жижиг ААН-үүд нэмэгдлээ. Бизнес регистрийн санд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 109.8 мянган ААН-ийн 86.3 хувь буюу 94.8 мянган ААН 1-9 ажилтантай байна. 1-9 ажилтантай жижиг ААН өмнөх оны мөн үеэс 7.3 мянгаар нэмэгдсэнээс 4.5 мянга нь худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байна (1-9 ажилтантай ААН-ийн 76 хувь буюу 71.8 мянган ААН худалдаа, үйлчилгээ эрхэлж байна).

Харин 10-19 ажилтантай ААН 6.9 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 597 ААН-ээр нэмэгдэхэд хөдөө аж ахуй, үйлчилгээ, боловсруулах салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ААН-үүд нэмэгдсэн нь нөлөөллөө. Худалдаа эрхэлдэг 20-оос дээш ажилтантай ААН-үүд өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурч харин үйлчилгээ, тээврийн салбарт үйл ажиллагаа явуулдаг ААН-үүд нэмэгджээ (Хүснэгт 2).

Хүснэгт 1. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тооны өөрчлөлт, ажиллагчдын тоогоор

Ажилчдын тооны бүлэг	ААН тоо, мянга	Өөрчлөлт, хувь	Тайлбар
1-9	94.8	8.3%	ААН-ийн тооны өсөлтийн 2.7 нэгж хувийг үйлчилгээ, 2.5 нэгж хувийг худалдаа, 1.5 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлсэн.
10-19	6.9	9.5%	Өсөлтийн 2/3-ыг хөдөө аж ахуй, 1.3 нэгж хувийг үйлчилгээ, 1.2 нэгж хувийг боловсруулах салбар бүрдүүлсэн.
20-49	5.2	0.8%	ААН-ийн тоо 39 ААН-ээр нэмэгдсэнээс 70 ААН үйлчилгээ, 9 ААН тээвэр, 5 ААН боловсруулах, 5 ААН ХАА-н салбарт байна. Харин худалдааны салбар 52 ААН, ус цахилгаан 1 ААН-ээр буурсан байна.

50-аас дээш	2.9	0.4%	ААН-ийн тоо 45 ААН-ээр нэмэгдсэнээс 27 ААН үйлчилгээ, 11 ААН тээвэр, 4 ААН барилга, 3 ААН уул уурхайн салбарт байна. Харин худалдааны салбарт 29 ААН, боловсруулах 3 ААН, ХАА 1 ААН-ээр буурсан байна.
Нийт	109.8	7.8%	

25. ААН-ийн бодит борлуулалтын орлого буурлаа. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар ААН-ийн бодит борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 18.1 хувиар буурч 8.5 их наяд

төгрөгт хүрлээ. Салбараар харвал уул уурхайгаас бусад бүх салбарт ААН-ийн бодит борлуулалт буурчээ. Тухайлбал ААН-ийн бодит борлуулалтын бууралтын 7.9 нэгж хувийг үйлчилгээ, 3.8 нэгж хувийг худалдаа, 2.0 нэгж хувийг боловсруулах, 1.9 нэгж хувийг ус, цахилгаан, 1.1 нэгж хувийг хөдөө аж ахуй, 1.1 нэгж хувийг тээвэр, 0.4 нэгж хувийг барилгын салбар тус тус бүрдүүлсэн байна. Харин уул уурхайн салбарын ААН-ийн борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 1.4. Аж ахуйн нэгж

Үйл ажиллагаа явуулж буй болон үйл ажиллагаа эхлээгүй ААН-ийн тооны өөрчлөлт, салбараар (ААН-ийн тоо)



Нийт бүртгэлтэй ААН-ийн тоо (мянга)



ААН-ийн бодит борлуулалт (их наяд төгрөг, 2015=100)



Шигтгээ 1. Хэрэглэгчийн итгэлийн индекс

2025 оны 1 дүгээр улиралд хэрэглэгчдийн ажлын олдцын одоогийн үнэлэмж болон ирээдүйн хүлээлт сайжирч Хэрэглэгчийн итгэлийн индекс 104.4-д хүрснээр өмнөх оны мөн үеэс 4.6 нэгжээр нэмэгдлээ.


Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК) болон Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөс тооцон гаргадаг Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ)-ээр эдийн засгийн ерөнхий байдал болон өрхийн санхүүгийн байдлын талаар хэрэглэгчид хэр зэрэг өөдрөг бодолтой байгааг хэмждэг. Хэрэглэгчийн итгэлийн индекс нь Өнөөгийн байдлын индекс /бизнесийн нөхцөл, ажлын олдоц/, Ирээдүйн хүлээлтийн индекс /бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлого/ гэсэн 2 дэд индекс /5 үзүүлэлтээс бүрдэх/-ээр тооцогдож байна. Ингэхдээ улс даяар санамсаргүй түүврийн аргаар хэрэглэгчдээс санал асуулга авч 0-200-ийн хооронд үнэлдэг бөгөөд индекс 200-д дөхөх тусам хэрэглэгчийн итгэл өндөр, 0-д дөхөх дусам хэрэглэгчийн итгэл сул, харин индекс 100-тай тэнцүү үед эдийн засаг хэвийн байна гэж үздэг.

ХИИ 2025 оны 1 дүгээр улиралд 104.4-д хүрэхэд ажлын олдцын үнэлэмж сайжирсан нь голчлон нөлөөллөө. Индексийн үнэлгээг бүрэлдэхүүн хэсгээр задалж Хүснэгт 3-т үзүүлэв.

Өнөөгийн байдлын индекс: Ажлын олдцын үнэлэмж сайжирч Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 19.6 нэгжээр нэмэгдлээ. Өнөөгийн байдлын индекс нь иргэд эдийн засгийн одоогийн нөхцөл байдлыг бизнесийн нөхцөл болон ажлын олдоц хэр байгаагаар үнэлснээр хэмждэг. 2025 оны 1 дүгээр улиралд Өнөөгийн байдлын индекс 126.7-д хүрч нэмэгдэхэд ажлын олдоц “сайн” гэж үнэлсэн иргэд өмнөх оны мөн үеэс 13.2 нэгжээр нэмэгдсэн нь нөлөөллөө. Харин бизнесийн нөхцөлийг “сайн” гэж үнэлсэн иргэд 3.1 нэгжээр буурсан байна.

Ирээдүйн хүлээлтийн индекс: Хэрэглэгчдийн эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлт муудаж Ирээдүйн хүлээлтийн индекс өмнөх оны мөн үеэс 0.2 нэгжээр буурлаа. Ирээдүйн хүлээлтийн индекс нь эдийн засгийн ойрын ирээдүйн нөхцөлийг иргэд хэрхэн харж буйг бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлогын хүлээлтийн үнэлгээгээр хэмждэг. 2025 оны 1 дүгээр улиралд Ирээдүйн хүлээлтийн индекс 97.2-д хүрч буурахад ирэх 6 сард бизнесийн нөхцөл муудна гэсэн хүлээлттэй хэрэглэгчид өмнөх оны мөн үеэс 2.0 нэгжээр нэмэгдсэн нь голчлон нөлөөллөө. Харин иргэд ирэх 6 сард ажлын олдцыг өмнөх оны мөн үеэс илүү өөдрөгөөр харж байгаа бол орлогын хувьд орлого хэвийн байна гэсэн иргэд өмнөх оны мөн үеэс 5.4 нэгжээр нэмэгджээ.

Зураг 1.5. Хэрэглэгчийн итгэлийн индекс улирлаар (2018=100)



Эх сурвалж: Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си)

Тайлбар: ХИИ болон түүний бүрэлдэхүүн индексүүдийн нөлөөгөөр засварлаж 2018 оны 4 дүгээр улирлын индексийг харьцуулж тооцсон б

Хүснэгт 2. Хэрэглэгчийн итгэлийн индекс бүрэлдэхүүн

	2024.I	2025.I	Өөрчлөг
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ			
Бизнесийн нөхцөл ▼			
Сайн	10.9	7.8	-3.1 ▼
Хэвийн	41.7	43.1	1.4 ▲
Муу	46.2	47.3	1.1 ▲
Ажлын олдоц ▲			
Сайн	24.9	38.1	13.2 ▲
Хэвийн	35.7	30.5	-5.2 ▼
Муу	37.0	30.0	-7.0 ▼
ИРЭЭДҮЙН ХҮЛЭЭЛТ ▼			
Бизнесийн нөхцөл ▼			
Сайн	15.2	14.5	-0.7 ▼
Хэвийн	61.4	60.2	-1.2 ▼
Муу	19.5	21.5	2.0 ▲
Ажлын олдоц ▲			
Сайн	24.3	24.8	0.5 ▲
Хэвийн	54.3	57.0	2.7 ▲
Муу	17.8	15.9	-1.9 ▼
Орлого ●			
Сайн	24.7	21.8	-2.9 ▼
Хэвийн	58.3	63.7	5.4 ▲
Муу	14.2	12.6	-1.6 ▼

Эх сурвалж: Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК)

1.4. Эдийн засгийн мөчлөг


26. Хөрөнгийн хуримтлал потенциал үйлдвэрлэлийн өсөлт нэмэгдэхэд эергээр нөлөөлөв. Байгаль цаг уурын тогтвортой байдлын нөлөөгөөр том малын зүй бус хорогдол буурч, үндсэн хөрөнгийн хуримтлалыг дэмжив. Биологийн өсөж үрждэг хөрөнгийн өсөлтийн голлох нөлөөгөөр үндсэн хөрөнгийн хуримтлал 2025 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс бодит дүнгээр 30.4 хувиар өсөж, потенциал үйлдвэрлэлийн өсөлтийн эрчим нэмэгдэж, 5 орчим хувьд хүрлээ. Мөн хөдөлмөрийн зах зээлийн идэвх хадгалагдаж, потенциал үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжсэн хэвээр байна.

27. Уул уурхайн салбарын өсөлт саарч, тээврийн салбар агшсанаар нийт үйлдвэрлэл потенциал түвшнээсээ 0.6 нэгж хувиар доогуур гарлаа. Зэсээс бусад металлын хүдэр болон нүүрс олборлох үйл ажиллагаа саарч, тээврийн өртөг буурснаар уул уурхай болон тээврийн салбар потенциал үйлдвэрлэлийн түвшнээс 0.7 нэгж хувиар доогуур гарлаа. Харин хөдөө аж ахуйн салбар сэргэлтийн голлох нөлөөгөөр уул уурхай болон тээврээс бусад салбаруудын үйлдвэрлэл потенциал түвшнээс 0.1 нэгж хувиар дээгүүр гарлаа.

Зураг 1.6. Үйлдвэрлэлийн зөрүү

1. Потенциал ДНБ-ий өсөлт

(хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Потенциал үйлдвэрлэлийг нэг хувьсагчтай шүүлтүүр буюу Ходрик-Прескотт, олон хувьсагчтай шүүлтүүр буюу Калман шүүлтүүр болон үйлдвэрлэлийн функцийн аргачлалаар тус тус тооцов.

2. Үйлдвэрлэлийн зөрүү

(потенциал ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Үйлдвэрлэлийн зөрүүг бодит болон потенциал ДНБ-ий зөрүүгээр тооцно. Үйлдвэрлэлийн зөрүүг Мөнгөний бодлогын шинжилгээний GAP загварт тулгуурлан олон хувьсагчийн Калманы шүүлтүүрийн аргаар тооцох аргаар тооцов.

Бүлэг 2

ТӨСВИЙН СЕКТОР

2.1. Төсвийн гүйцэтгэл

2.2. Төсвийн бодлогын төлөв

2.3. Засгийн газрын өрийн тогтвортой байдал

2. ТӨСВИЙН СЕКТОР

ТОЙМ

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 оны эхний улиралд нүүрсний экспортын орлогын бууралтын нөлөөгөөр 6.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд төгрөг буюу 16.0 хувиар буурч, тэнцвэржүүлсэн тэнцэл 353.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Төсвийн нийт зарлага 6.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 14.2 хувиар тэлэхэд урсгал зарлагын өсөлт, тэр дундаа төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Засгийн газрын нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн өрийн үлдэгдэл 34.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.8 их наяд төгрөгөөр буюу 16.3 хувиар өссөн байна.

2.1. Төсвийн гүйцэтгэл

28. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарлаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 оны эхний улирлын байдлаар 6.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд төгрөг буюу 16.0 хувиар буурсан байна. Нэгдсэн төсвийн нийт зарлага 6.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 14.2 хувиар өссөнөөр төсвийн нийт тэнцэл 70.4 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцэл 353.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

29. Нүүрсний үнэ буурснаар уул уурхайн салбараас төсөвт төвлөрөх орлого буурлаа. Нэгдсэн төсвийн нийт орлого 2025 оны нэгдүгээр улиралд 6.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд төгрөг буюу 16.2 хувиар буурлаа. Орлогын бууралтад дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнийн уналт голлон нөлөө үзүүлсэн ба нүүрсний экспортын хилийн дундаж үнэ 2025 оны эхний улиралд 76.6 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 37.9 хувиар буурсан байна. Тодруулбал, ААНОАТ өмнөх оны мөн улирлаас 640.0 тэрбум төгрөг буюу 31.6 хувиар, АМНАТ-ийн нийт орлого 852.0 тэрбум төгрөг буюу 57.3 хувиар тус тус буурсан нь төсвийн нийт орлогын бууралтад голлох нөлөө үзүүллээ..

30. Цалин нэмэгдэж, даатгуулагчдын тоо өссөнөөр ХХОАТ болон нийгмийн даатгалын орлого нэмэгдлээ. Ажилчдын тоо 2025 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 48 мянгаар нэмэгдэж 1 сая 380 мянгад хүрсэн нь хөдөлмөр эрхлэлтэд суурилсан татварын орлогыг дэмжлээ. Тухайлбал, нийгмийн даатгалд албан журмаар даатгуулагчдын тоо өмнөх оны мөн үеэс 86.4 мянгаар, сайн дураар даатгуулагчдын тоо 30.8 мянгаар өссөнөөр нийт даатгуулагчдын тоо 977.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар өссөн байна. Улмаар нийгмийн даатгалын орлого 1.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 28.8 хувиар нэмэгджээ. Мөн нэрлэсэн цалингийн өсөлт хадгалагдсан нь ХХОАТ-ын орлогод эергээр нөлөө үзүүлж, 635.8

тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 18.7 хувиар өссөн үзүүлэлт боллоо.

31. Өрхийн удаан эдэлгээт барааны худалдан авалт буурч, худалдааны салбар агшсанаар НӨАТ-ын орлогын өсөлт саарав. Зах зээлийн худалдан авалтын чадавхыг илэрхийлдэг нэмэгдсэн өртгийн албан татварын орлого тус оны эхний улиралд 1.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар буурлаа. Тус бууралтад НӨАТ-ын буцаан олголт өмнөх оны оны мөн үеэс 123.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлсэн хэдий ч дотоодын болон импортын бараанд ногдуулсан НӨАТ-ын орлогын өсөлт түүхэн дунджаас бага байв. Тухайлбал, дотоодын барааны НӨАТ-ын орлого сүүлийн 15 жилийн эхний улиралд дунджаар 24.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тус үзүүлэлт 2025 оны эхний улиралд 4.5 хувиар өссөн байна. Түүнчлэн, аж үйлдвэрийн орцын импортын өсөлт саарснаар импортын бараа, үйлчилгээний НӨАТ-ын орлогын өсөлт өмнөх 15 жилийн өсөлтийн дунджаас 15.9 нэгж хувиар бага буюу 7.6 хувьд хүрлээ.

32. Онцгой албан татварын орлого импортын пиво, тамхи, суудлын автомашины биет хэмжээний өсөлтийн нөлөөгөөр нэмэгдлээ. Гаалийн албан татварын орлого 2025 оны эхний улиралд 394.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 12.1 хувиар өссөн байна. Мөн онцгой албан татварын орлого 294.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх жилээс 14.4 тэрбум төгрөгөөр буюу 5.2 хувиар өслөө. Тус өсөлтөд импортын тамхины онцгой албан татвар 6.0 тэрбум төгрөг буюу 21.2 хувиар, импортын пивоны онцгой албан татвар 2.3 тэрбум төгрөг буюу 2.6 дахин, суудлын автомашины онцгой албан татвар 18.9 тэрбум төгрөг буюу 12.3 хувиар тус тус өссөн нь голчлон нөлөөллөө. Түүнчлэн, 2000 оноос хойших онцгой албан татварын орлогын эхний улирлын дундаж өсөлт 20.3 хувь байгаа бол 2025 оны эхний улиралд өсөлт 5.2 хувь болж буурсан байна. Нийслэлийн Засаг даргын "Нийслэл


хотод авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар олгох шалгуур үзүүлэлтийг батлах тухай” А/1348 дугаар захирамжийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөхөөр заасан. Тус захирамжтай холбоотойгоор иргэдийн худалдан авах суудлын

автомашины эрэлт нэмэгдсэн бөгөөд 2025 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар их 78,464 суудлын автомашин манай улсад импортлогдсон нь суудлын автомашины онцгой албан татварын орлогод эерэг нөлөө үзүүлжээ.

Зураг 2.1. Төсвийн орлого

1.Төсвийн тэнцэл


(их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

2.Татварын орлогын өсөлтөд эзлэх хувь, төрлөөр


(хувь)



Эх сурвалж: Сангийн яам

3.Нэмэгдсэн өртгийн албан татварын орлого

(хувь)



Эх сурвалж: УСХ.

33. Төсвийн урсгал зардлын өсөлтөд цалин, тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн нь голлон нөлөөллөө. Төсвийн урсгал зардал өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд төгрөг буюу 25.6 хувиар өсөж нийт зардлын өсөлтөд эерэг нөлөө үзүүлээ. Урсгал зардлын дийлэнх хувийг төрийн албан хаагчийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж болон зээлийн хүүгийн төлбөр зэрэг хуулиар зохицуулагддаг, өсөн нэмэгдэх зардлууд бүрдүүлдэг. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд төрийн албан хаагчдын үндсэн цалинг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлснээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 1.5 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 39.8 хувиар өсөж, нэгдсэн төсвийн урсгал зардлын өсөлтийн хамгийн өндөр буюу 9.2 нэгж хувийг бүрдүүлээ. Мөн тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн дагуу тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлснээр нийгмийн даатгалын тэтгэвэр,

тэтгэмжийн зардал өмнөх оны мөн үеэс 326.4 тэрбум төгрөгөөр өссөн байна. Улмаар нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн зардал урсгал зардлын өсөлтийн 6.9 нэгж хувийг бүрдүүлсэн байна.


34. Засгийн газрын зээлийн хүүгийн төлбөрийн төсвийн нийт зардалд эзлэх хэмжээ өмнөх оны мөн үеэс буурлаа. Нийт зээлийн хүүгийн үйлчилгээний төлбөр 2025 оны нэгдүгээр улиралд 408.1 тэрбум төгрөгийн төлөлт хийгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 6.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тодруулбал, гадаад зээлийн хүүгийн төлбөрт 407.1 тэрбум төгрөг, дотоод зээлийн төлбөрт 1.0 тэрбум төгрөгийг тус тус төлсөн байна. Засгийн газрын зээлийн хүүгийн зардлын хэмжээ 2024 оны эхний улиралд нийт зардлын 7.1 хувь, урсгал зардлын 8.6 хувийг, 2025 оны эхний улиралд нийт зардлын 6.3 хувь, урсгал зардлын 6.9 хувийг бүрдүүлж өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан хэдий ч цаашид өрийн нийт төсвийн ачааллыг бууруулах, урт хугацаанд төсвийн тогтвортой байдлыг сайжруулахад

гадаад өрийн өсөлтийг хязгаарлах төсвийн бодлого чухал байна.

35. Эрчим хүчний салбарын татаас буурч, нийтийн тээврийн татаас өсөлттэй байна. Нэгдсэн төсвөөс 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар нийт 243.4 тэрбум төгрөгийн татаасыг олгосон бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 82.0 хувиар өссөн байна. Тус өсөлтөд хувийн хэвшилд олгосон татаасны хэмжээ 224.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.5 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөсөн байна. Тодруулбал, зээлийн хүүгийн болон нийтийн тээврийн байгууллагуудын алдагдалд олгох татаасны хэмжээ нийт татаасны 42.7 хувийг бүрдүүлж өмнөх оны мөн үеэс 20.3 нэгж хувиар өссөн байна. Нийтийн тээврийн алдагдалд олгосон татаас 89.7 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 3.1 дахин, зээлийн хүүгийн татаас 14.2 тэрбум төгрөг

болж, 12 дахин өссөн байна. Нийтийн тээврээр зорчих үнийг өдөрт 1,000 төгрөг³ болгон цагийн хязгаарлалтгүй дөрвөн удаа зорчих шинэ зохицуулалт 2025 оны нэгдүгээр сараас эхлэн хэрэгжиж эхэлсэн хэдий нийтийн тээврийн алдагдалд олгох төсвийн татаас өсөлттэй хэвээр байна. Иймд нийтийн тээврийн салбарын бодит өртгийн судалгаа, бодлого, төлөвлөлт, удирдлагын менежментийг сайжруулах шаардлагатай байна. Эрчим хүчний салбарын алдагдалд 2025 оны эхний улирлын байдлаар төсвөөс татаас олгоогүй байна. Бодит өртгөөс доогуур үнээр зарж байсан цахилгааны үнэ тарифыг 2024 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс гурван цагийн ялгаварт тарифыг шинээр нэвтрүүлж, ойролцоогоор 30 гаруй хувиар нэмснээр эрчим хүчний цахилгаан станцын алдагдалд олгох татаасны хэмжээ буурсан байна.

Зураг 2.2. Төсвийн зарлага



³ Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны хоёрдугаар сарын "Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх таксинаас

бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох тухай" 21 дугаар тогтоол

36. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс саарлаа. Нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалт 2025 оны эхний улиралд 592.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 29.7 хувиар буурсан бол нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 7.8 хувьтай байна. Эдийн засгийн ангиллаар авч үзвэл, нийт хөрөнгө оруулалтын зардлын 76.8 хувийг барилга байгууламж, 12.4 хувийг бусад хөрөнгө, 8.6 хувийг тоног төхөөрөмж, 2.1 хувийг их засварт зарцуулжээ. Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардал өмнөх оны мөн үетэй харьцуулахад тус тус харгалзан 27.8 хувь, 18.9 хувь болон 62.3 хувиар буурч, бусад хөрөнгийн зардал 20.3 хувиар өссөн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 9.4 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 623 төсөл, арга хэмжээг 3.2 их наяд төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2025 оны эхний улиралд уг санхүүжилтийн гүйцэтгэл 5.0 хувьтай байна. Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын 72.2 хувь буюу 427.5 тэрбум төгрөг нь орон нутгийн төсөв (Засгийн Газрын бонд, гадаад зээл багтсан)-өөс санхүүжиж, өмнөх оны мөн үеэс 3 дахин өссөн байна.

2.2. Төсвийн бодлогын төлөв

37. Мөчлөг сөрсөн төсвийн тэлэх бодлого хэрэгжиж байна. Төсвийн тэнцэлд үзүүлэх төсвийн бодлогын нөлөөг төсвийн төлөв, төсвийн бодлогоос хамаарахгүй эдийн засгийн мөчлөгийн нөлөөг төсвийн автомат тогтворжуулагчаар ⁴, өрийн үйлчилгээний нөлөөг хүүгийн зардлаар илэрхийлэн зураг 2.4-т харууллаа. Төсвийн бодлогын жилийн төлөв, чиг хандлагыг дүгнэх зорилгоор дээрх үзүүлэлтүүдийн улирлын нөлөө арилгасан дүнгүүдийн сүүлийн дөрвөн улирлын дунджаар

тооцоолсон болно. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл потенциал ДНБ-ий 3.3 хувьтай тэнцэх алдагдалтай гарахад автомат тогтворжуулагч 0.1 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн бол төсвийн төлөв 1.9 нэгж хувь, хүүгийн зардал 1.4 нэгж хувьтай тэнцэх сөрөг нөлөө үзүүлж, төсөвт дарамт учруулсан байна. Нийт зардлын өсөлт улирлын нөлөөг арилгасан тэнцвэржүүлсэн орлогын сүүлийн дөрвөн улирлын дундаж өсөлтөөс өндөр байгаа нь мөчлөг сөрсөн төсвийн тэлэх бодлого хэрэгжиж байгааг харуулах бөгөөд энэ нь төсвийн алдагдлын голлох шалтгаан болсон байна.

38. Эдийн засгийн идэвхжил суларснаар төсөвт үзүүлэх автомат тогтворжуулагчийн нөлөө саарлаа. Иргэдийн бодит орлого нэмэгдэж, эдийн засгийн дотоод эрэлт сайжирсан нөлөөгөөр автомат тогтворжуулагч тэнцвэржүүлсэн тэнцэлд эерэг нөлөө үзүүлсэн. Гэсэн хэдий ч 2025 оны эхний улиралд ДНБ-ний агшилтаас шалтгаалсан буюу төсвийн бодлогоос үл хамаарах дөрвөн улирлын дундаж автомат тогтворжуулагчийн нөлөө 0.1 нэгж хувь буюу 6.7 тэрбум төгрөгт хүрч 2024 оны 1-р улиралтай харьцуулахад буурсан байна.

39. Төсвийн импульс эерэг утгатай гарсан нь төсвийн бодлого өмнөх онтой харьцуулахад илүү тэлэх чиглэлд эрчимжиж байгааг харуулж байна. Төсвийн импульс нь төсвийн тэлэх, эсвэл хумих бодлогын хурдыг төсвийн төлөвийн жилийн өөрчлөлтөөр тооцон харуулдаг. Улирлын нөлөө арилгасан сүүлийн дөрвөн улирлын дунджаар тооцсон төсвийн импульс 2025 оны эхний улиралд потенциал ДНБ-ий 5.4 хувь буюу 1.1 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа нь төсвийн тэлэх бодлогын хурд тус хэмжээнд нэмэгдсэнийг илтгэж байна.


⁴ Эдийн засгийн тэлэлт буюу сэргэлтийн үед эдийн засгийн үйл ажиллагаа эрчимжихийн хэрээр төсвийн орлого нэмэгдэж, эсрэгээрээ эдийн засгийн агшилт буюу уналтын үед татварын орлого буурч, ажилгүйдэл өссөнөөр ажилгүйдлийн тэтгэмж гэх

мэт төсвийн зардал ямар нэг бодлогын оролцоогүйгээр жамаараа нэмэгддэг. Ийнхүү засгийн газрын төсвийн бодлогоос үл хамааран төсвийн тэнцэл өөрчлөгдөж, эдийн засгийг тогтворжуулах чиглэлд ажиллаж байгааг төсвийн тэнцлийн автомат тогтворжуулагч гэнэ.

Зураг 2.3. Төсвийн тэнцэл, төсвийн төлөв, автомат тогтворжуулагч

1.Төсвийн нийт тэнцэл⁵


(потенциал ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам
Тэмдэглэл: Улирлын нөлөө арилгасан сүүлийн дөрвөн жилийн дунджаар тооцов.

2.Төсвийн төлөв, импульс


(потенциал ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам
Тэмдэглэл: Улирлын нөлөө арилгасан сүүлийн дөрвөн жилийн дунджаар тооцов.

3.Үйлдвэрлэлийн зөрүү, автомат тогтворжуулагч

(Зүүн тэнхлэг: тэрбум төгрөг, Баруун тэнхлэг: потенциал ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам
Тэмдэглэл: Улирлын нөлөө арилгасан сүүлийн дөрвөн жилийн дунджаар тооцов.

⁵Энд хүүгийн зардал болон төсвийн төлөвийн эерэг утга нь төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх учир зурагт ойлгомжтой харагдуулах үүднээс тухайн утгуудыг -1-ээр үржүүлж харууллаа.

2.3. Засгийн газрын өрийн тогтвортой байдал

40. Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 4 улирал дараалан өслөө. Засгийн газрын өр 2024 оны нэгдүгээр улирлаас хойш 4 улирал дараалан өсөж, 2025 оны эхний улирлын байдлаар 34.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 4.8 их наяд төгрөгөөр буюу 16.3 хувиар нэмэгдсэн байна. Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хэмжээ 37.3 хувь буюу өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувийн өсөлттэй байна. Засгийн газрын өрийн хэмжээ 2025 оны эхний улиралд хүлээгдэж буй ДНБ-ий 37.3 хувьтай тэнцүү байна. Тус үзүүлэлт 2023 оны жилийн эцэст 44.7 хувь, 2024 оны эцэст 41.8 хувьд хүрсэн байсан.

41. Засгийн газрын нийт өрийн нэмэгдүүлэхэд нийслэлийн шинээр гаргасан бонд голлон нөлөөлсөн байна. Засгийн газрын өр 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар буурахад үндсэн төлбөр буурсантай холбоотойгоор гадаад үнэт цаасны өр 5.7 нэгж хувь, өрийн баталгаа, барих шилжүүлэх концессын өр төлбөрийн бууралт 3.7 нэгж хувиар нөлөөлсөн байна. Засгийн газрын өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар өсөхөд орон нутгийн зээллэг 2.6 их наяд төгрөг (8.8 нэгж хувь), гадаад зээл 1.8 их наяд төгрөг (6.2 нэгж хувь)-өөр тус тус өссөн нь голлох нөлөө үзүүлсэн

байна. Өрийн удирдлагын тухай хуулийн 2024 оны 1 дүгээр сарын 17-ны нэмэлт, өөрчлөлтөөр нийслэл хот хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зориулалтаар гадаад үнэт цаас гаргах нөхцөлийг бий болгож шинэчлэн баталсан. Улмаар нийслэлээс 2024 онд Засгийн газрын нийт өрийн 7.7 хувьтай тэнцүү хэмжээний 2.6 их наяд төгрөгийн богино хугацаат /1-5 жил/ үнэт цаас арилжаалсан байна. Тус үнэт цаасны эх үүсвэрээр “Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл”, “Бөөрөлжүүтийн ДЦС”, “Батарей хуримтлуурын станц”, “Авто зам, замын байгууламжийн засвар,

Хүснэгт 5. НЗДТГ-аас гаргасан үнэт цаасны мэдээлэл


№	Зориулалт	Гаргасан огноо	Эргэн төлөх огноо	Нэрлэсэн үлдэгдэл
1	Зам засвар, арчилгаа	2024.06.25	2025.06.25	106.2
2	Зам засвар, арчилгаа	2024.06.25	2026.06.25	106.8
3	Бөөрөлжүүтийн ДЦС барих	2024.06.25	2027.06.25	321.9
4	Батарей хуримтлуурын станц барих	2024.12.26	2029.12.26	298.4
5	Сэлбэ дэд төвийг орон сууцжуулах	2024.11.29	2027.08.29	1,725.10
Нийт				2,558.40

Эх сурвалж: Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн хэрэгжилтийн тайлан


Зураг 2.4. Засгийн газрын өр

1.Засгийн газрын өр


(зүүн тэнхлэг: их наяд төгрөг, баруун тэнхлэг: хувь)



2.Засгийн газрын өрийн өөрчлөлтийн задаргаа, жилийн өсөлт (хувь)



3.Өрийн үйлчилгээний төлбөрийн динамик (ДНБ-д эзлэх хувь)



шинэчлэлтийн ажил”, “Ариутгах Бохир усны Туул-1 коллектор болон үерийн байгууламж” зэрэг төслүүдийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

42. Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөр цар тахлаас хойш харьцангуй тогтворжсон байна. Засгийн газрын өрийн хүүгийн төлбөр 2016-2017 онд ДНБ-ий 4.1 хувьтай тэнцэн, түүхэн дээд түвшинд хүрсэн бөгөөд цар тахлаас хойш тогтворжиж, 2024 оны эцэст ДНБ-ий 1.5 хувьд хүрсэн. Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ хөгжиж буй улс орнуудын хувьд 2000 оноос буурах хандлагатай байсан ч цар тахлын нөлөөгөөр өсөж, 2024 онд дунджаар 1.9 хувьд хүрсэн байна. Тус үзүүлэлт бага дунд орлоготой орнуудын дундаж тус үед 2.2 хувьтай байгаа бол хөгжингүй улс орнуудын дундаж хамгийн өндөр буюу 3.7 хувьтай байна. Цаашид зээлийн үйлчилгээний төлбөр өндөр санхүүжилтүүдийн эх үүсвэрийг эдийн засгийн үр өгөөжтэй бүтээн байгуулалтуудад зарцуулах нь чухал байна.

43. Засгийн газрын нийт өрд гадаад өрийн эрсдэл давамгай байна. 2025 оны нэгдүгээр улиралд Засгийн газрын нийт өрийн 95.9 хувийг гадаад өр бүрдүүлж байгаа нь Засгийн газрын өрийг ханшийн шок болон бусад гадаад орчны нөлөөнд мэдрэг болгож байна. Гадаад өрийн эрсдэл өндөр байгаатай холбогдуулан төсвийн алдагдалд үзүүлэх хүүгийн зардлын нөлөө хамгийн өндөр байна. Түүнчлэн 2026-2028 онуудад тус бүр 978 сая ам доллар, 918.5 сая ам.доллар, 1.0 тэрбум ам долларын гадаад зээлийн үндсэн төлбөрийн эргэн төлөлт хийх хүлээлттэй байна.

44. Засгийн газрын өрийн дунд хугацааны төлөвт үндсэн тэнцэл, бодит ДНБ-ий нөлөө өндөр байна. Засгийн газрын өрийн дунд хугацааны төлөв нь макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдэд хэр мэдрэг байгааг өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр дүгнэдэг. Өрийн динамик шинжилгээний суурь


төсөөллөөр 2025-2027 онуудад харгалзан ДНБ-ий өсөлт 6 хувьд, ДНБ-ий дефлятор болон ханшийн сулрал сүүлийн 10 жилийн дундаж түвшинд, үндсэн тэнцэл төсөөллийн орчимд бусад макро үзүүлэлтүүд 2024 оны түвшинд тогтвортой байна гэж үзвэл Засгийн газрын өр 2025 онд ДНБ-ий 38.1 хувьтай тэнцэхээр байна. Голлох үзүүлэлтүүдэд 2025, 2026 онуудад 1 стандарт хазайлт бүхий шок тооцоход, шокийн нөлөөгөөр 2027 онд Засгийн газрын өр суурь түвшнээс 6.4-9.9 хувиар өсөх магадлал харгалзан 25% байна. Энэ нь засгийн газрын өр макро эдийн засгийн тодорхойгүй байдлын шокийн нөлөөнөөс өндөр мэдрэг байгааг харуулж байна.

45. Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангахад үндсэн тэнцлийг ашигтай түвшинд байлгах нь чухал байна. Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлсийг өрийн динамик шинжилгээгээр үнэлэв. Засгийн газрын нэрлэсэн өрийн ДНБ-д эзлэх хэмжээ 2020 онд 10.8 хувиар өссөн бөгөөд үүнд үндсэн тэнцлийн алдагдал 6.7 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Нэрлэсэн өр 2022 онд 2.4 хувиар буурахад бодит ДНБ-ий өсөлт 2.1 нэгж хувиар эерэг нөлөө, валютын ханшийн сулрал 9.3 нэгж хувьтай тэнцэх сөрөг нөлөө үзүүлжээ. Цаашид Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангахад ДНБ-ий бодит өсөлт болон үндсэн тэнцлийн алдагдал голлох үүрэг гүйцэтгэхээр байна. Иймд цаашид макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь чухал байгааг тус тооцооллын үр дүн харуулж байна.

Зураг 2.5. Засгийн газрын өрийн тогтвортой байдал

1.Засгийн газрын өрд үзүүлэх нэрлэсэн гадаад хүүгийн болон ханшийн сөрөг шокийн нөлөө


(ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

2.Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс

(өөрчлөлтөд эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Бүлэг 3

МӨНГӨНИЙ СЕКТОР

3.1. Инфляц

3.2. Мөнгө ба санхүүгийн салбар

3. МӨНГӨНИЙ СЕКТОР

ТОЙМ

Инфляц 2025 оны 1 дүгээр улиралд 9.1 хувьд хүрч, төв банкны зорилтоос өндөр түвшинд хадгалагдлаа. Эдийн засгийн дотоод идэвхжил үргэлжилснээр эрэлтийн гаралтай инфляц өсөхийн зэрэгцээ нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт эрчимжсэн байна. Төв банкнаас мөнгөний бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 12 хувьд хүргэв. Арилжааны банкнуудын зээлийн өсөлт өндөр хэвээр хадгалагдаж, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлох нөлөө үзүүлсээр байна. Мөн банкны салбарын зээлийн чанар болон ашигт ажиллагаа тогтвортой хадгалагдлаа.

3.1. Инфляц

46. Инфляц 2025 оны 1 дүгээр улиралд төв банкны зорилтот түвшнээс өндөр хадгалагдав. Инфляц 2025 оны 3 дугаар сард 9.1 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар⁶ өслөө. Инфляцын 2.3 нэгж хувийг хүнсний бараа, 2.1 нэгж хувийг орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, 1.1 нэгж хувийг хувцас, бөс бараа, гутлын бүлэг, 1.0 нэгж хувийг боловсролын үйлчилгээ бүрдүүллээ. Инфляц өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар эрчимжихэд өрхийн цахилгааны төлбөр, орон сууцны түрээсийн зардал, автомашин, автобусны билетийн үнийн өсөлт голчлон нөлөөлсөн байна.


47. Импортын болон дотоодын бараа, үйлчилгээний инфляц өсөх хандлагатай байв. Импортын барааны инфляц 2025 оны 3 дугаар сард 5.1 хувь гарч, өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар өсөж, нийт инфляцын 27 хувийг бүрдүүллээ. Импортын инфляцын 91 гаруй хувийг хүнсний бус барааны үнийн өсөлт тайлбарлаж байна. Үүнд, хувцас, бөс бараа, гутал болон автомашины үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Дотоодын бараа, үйлчилгээний инфляц 2025 оны 3 дугаар сард 12.8 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 4.4 нэгж хувиар эрчимжиж, нийт инфляцын 73 хувийг

бүрдүүлсэн байна. Дотоодын инфляцад хүнс болон үйлчилгээний үнийн өсөлт голлох нөлөөтэй байна. Тодруулбал, 2025 оны 3 дугаар сард үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 10.2 нэгж хувиар эрчимжиж, инфляцын 4.0 нэгж хувийг бүрдүүлжээ. Үйлчилгээний үнийн өсөлт эрчимжихэд өрхийн цахилгааны төлбөр, орон сууцны түрээс болон нийтийн хоолны үйлчилгээний үнэ өссөн нь нөлөөлөв.


48. Эрэлт, нийлүүлэлтийн шалтгаантай инфляц эрчимжлээ. Эрэлтийн (суурь) инфляц 2025 оны 1 дүгээр улиралд 9.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар эрчимжсэн байна. Үүнд эдийн засгийн дотоод идэвхжил хадгалагдсан болон цахилгааны тарифын шинэчлэлээс үүдэлтэй шууд бус нөлөө зэрэг хүчин зүйлс нөлөөллөө. Эрэлтийн инфляц нийт инфляцын дийлэнх буюу 64 хувийг тайлбарлаж байна. Нийлүүлэлтийн гаралтай инфляц 2025 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар 8.6 хувь гарч, өмнөх оны мөн үеэс 1.9 нэгж хувиар эрчимжсэн байна. Нийлүүлэлтийн инфляц эрчимжихэд өрхийн цахилгааны тариф нэмэгдсэн болон малын зүй бус хорогдолтой холбоотойгоор махны үнэ өссөн нь нөлөөлөв.

Зураг 3.1. Инфляцын бүрэлдэхүүн


1.Инфляц ба зорилтот түвшин



2.Инфляцын бүрэлдэхүүн



3.Суурь инфляц



⁶ Үндэсний Статистикийн Хорооноос 2025 оны 2 дугаар сараас эхлэн инфляцыг тооцдог хэрэглээний бараа, үйлчилгээний 2020 оны суурийг 2023 оноор шинэчилж,

тооцоолж эхэлсэн. 2023 оны шинэчилсэн суурьтай тооцооллоор инфляц 2024 оны 3 дугаар сард 6.2 хувь байна.

49. Хүнсний ба хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц өмнөх улирлаас өслөө. Хүнсний барааны инфляц 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 8.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.4 нэгж хувиар буурсан байна. Нийт инфляцын 2.3 нэгж хувийг бүрдүүлсэн хүнсний инфляц өмнөх оны мөн үеэс саарахад талх, гурил, будаа, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнийн өсөлт саарсан нь голчлон нөлөөлсөн байна. Харин мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 17.5 хувиар өссөнөөр инфляцыг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэх нөлөө үзүүлжээ. Түүнчлэн, хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц 9.4 хувь хүрч, өмнөх оны мөн үеэс 4.5 нэгж хувиар өслөө. Хүнсний бус инфляц өмнөх улирлаас эрчимжигдэж орон сууцны бодит түрээсийн үнэ өмнөх оны мөн үеэс 48.5 хувиар, өрхийн цахилгааны төлбөр 65 хувиар, суудлын автомашины үнэ 10.9 хувиар болон хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 8.5 хувиар тус тус өссөн нь голлох нөлөө үзүүлэв.


50. Олон улсад чингэлэг тээврийн үнэ өмнөх оны мөн үеэс буурсан бол хүнсний үнийн индекс өссөн байна. Дэлхийн чингэлэг тээврийн үнэ Улаан тэнгис дэх Суэцийн сувагт үүссэн халдлагын нөлөөгөөр 2024 оны 2 дугаар сараас хойш эрчтэй өсөөд байсан бол 2024 оны 8 дугаар сараас аажмаар буурч эхэлсэн. Дэлхийн

чингэлэг тээврийн үнэ 2025 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар 40 фут чингэлэг тутам 2,168 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 26 хувиар буурсан бол цар тахлын өмнөх үеэс 57.2 хувиар өндөр байна. Хүнсний үнийн индекс 2025 оны 1 дүгээр улирлын эцэст 127.1 болж, өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өслөө. Дэлхийн зах зээл дээр мах, ургамлын тосны үнэ өссөн бол үр тариа, элсэн чихрийн үнэ буурч, сүүн бүтээгдэхүүний үнэ тогтвортой хадгалагдсан байна. 2025 оны 3 дугаар сарын байдлаар Хятад, Япон, Киргизстан, Турк, Шри-Ланк, Америк, Их-Британи улсууд болон Евро бүсийн инфляц буурсан бол Гүрж, Казакстан, Солонгос, Орос улсуудын инфляц өссөн байна.


51. Бодлогын хүү зохистой түвшинд байна. Төв банкнаас 2025 оны 3 дугаар сард бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 12 хувьд хүргэсэн ба 2025 оны 1 дүгээр улирлын бодлогын хүүний дундаж түвшин 10.7 хувь байна. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар бодлогын хүүний зохистой утгыг илэрхийлэх Тэйлорын дүрмээр тооцсон хүү 11.0 хувь байгаа нь бодлогын хүүний дундаж түвшинтэй нийцтэй байна. Түүнчлэн, 2025 оны 1 дүгээр улиралд бодит хүүний зөрүү мөнгөний нөхцөлийг сулруулах нөлөө өмнөх улирлаас нэмэгдлээ. Харин бодит ханшийн зөрүүний мөнгөний нөхцөлийг чангаруулах нөлөө өссөн үзүүлэлттэй байна. Зээлийн өсөлт өндөр

Зураг 3.2. Тэйлорын хүү, мөнгөний нөхцөлийн индекс

1.Бодлогын хүү ба Тэйлорын хүү



2.Мөнгөний нөхцөлийн индекс



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Тэйлорын дүрмээр тооцсон хүү нь бодлогын хүүний зохистой утгыг илэрхийлэх бөгөөд өмнөх улирлын бодлогын хүү, инфляц, инфляцын хүлээлт, нэрлэсэн хүү зэрэг хувьсагчдыг агуулсан тэгшитгэл юм.

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол


Тэмдэглэл: Мөнгөний нөхцөлийн индекс нь эдийн засаг дахь мөнгөний бодлогын нөлөөг хэмжих үзүүлэлт юм. Мөнгөний нөхцөлийн индексийг Мөнгөний бодлогын шинжилгээний GAP арга зүйг ашиглан тооцоолов.

хадгалагдахын зэрэгцээ геополитикийн тогтворгүй байдал, тарифын бодлого зэрэг инфляцыг нэмэгдүүлэх эрсдэлүүд хадгалагдаж


байгаа тул бодлогын хүүг зохистой түвшинд хадгалах шаардлагатай байна.

Зураг 3.3. Голлох бүтээгдэхүүний үнэ


1.Хонины мах (кг/төгрөг)




2.Үхрийн мах (кг/төгрөг)



3.Гурил, 1-р зэрэг (кг/төгрөг)




4.Талх, Атар (төгрөг)




5.Ургамлын тос (төгрөг)




6.Төмс (төгрөг)



7.Сүү, савласан (литр/төгрөг)



8.Дизель түлш (литр/төгрөг)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Голлох зарим бүтээгдэхүүний үнийн динамикийг сараар харуулав.

3.2. Мөнгө ба санхүүгийн салбар

52. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарлаа.


Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2025 оны 1 дүгээр улирлын эцэст 10.9 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 10.0 нэгж хувиар буурлаа. Эх үүсвэр талаас төгрөгийн хадгаламж мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голлон бүрдүүлж байна. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 10.7 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 0.7 нэгж хувийг төгрөгийн харилцах, 1.2 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 0.2 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлсэн бол гадаад валютын харилцах 1.9 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлээ. Байршуулалт талаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 22.9 нэгж хувийг дотоод цэвэр актив бүрдүүлсэн бол гадаад цэвэр актив 12.0 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлсэн байна. Үүнд, 2025 оны 3 сард гаднын санхүүгийн байгууллагаас авсан зээл нэмэгдсэнтэй холбоотойгоор гадаад цэвэр активын өсөлт саарсан нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарахад голлон нөлөөлсөн байна. Харин дотоодын зээлийн өсөлт өндөр хэвээр хадгалагдсанаар дотоод цэвэр актив өсжээ.

53. Зээлийн өсөлт өндөр хэвээр байна. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 38.6 их наяд төгрөг болж, жилийн өсөлт 33.5 хувьд хүрсэн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 68 хувь буюу 26.3 их наяд

төгрөгийг бизнесийн зээл, 32 хувь буюу 12.3 их наяд төгрөгийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. Бизнесийн зээлийн үлдэгдлийн өсөлт 2025 оны 1 дүгээр улиралд 34.4 хувь болж, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 13 нэгж хувиар эрчимжсэн байна. Бизнесийн зээлийн өсөлтөд бөөний болон жижиглэн худалдааны зээл өмнөх оны мөн үеэс 27.1 хувиар, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны зээл 31 хувиар, уул уурхай, олборлолтын зээл 61 хувиар, хөдөө аж ахуйн зээл 153.1 хувиар тус тус өссөн нь голлох нөлөө үзүүлжээ. Хэрэглээний зээлийн үлдэгдлийн өсөлт 2025 оны 1 дүгээр улиралд 31.5 хувьд хүрч, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 4.2 нэгж хувиар саарсан байна. 2023 оноос хойш дундаж цалин тасралтгүй өссөнөөр цалингийн зээлийн өсөлт хэрэглээний зээлийн өсөлтөд голлох нөлөөтэй байлаа. Мөн түүнчлэн, өр ба орлогын хязгаарлалтгүй тэтгэврийн болон хадгаламж барьцаалсан зээл нэмэгдсэн нь хэрэглээний зээлийн өсөлтөд нөлөөлжээ. Цалингийн зээл өмнөх оны мөн үеэс 43 хувиар, тэтгэврийн зээл 39 хувиар, хадгаламж барьцаалсан зээл 19.1 хувиар тус тус өссөн байна.

54. Бизнесийн зээлийн олголт сэргэж, хэрэглээний зээлийнх саарч эхэллээ. Банкны салбарын 2025 оны 1 дүгээр улиралд шинээр олгосон нийт зээлийн хэмжээ 14.7 их наяд төгрөг

Ураг 3.4. Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үзүүлэлтүүд




болж, өмнөх оны мөн үеэс 3.0 их наяд төгрөгөөр буюу 26.1 хувиар өслөө. Шинээр олгосон зээлийн 61 хувийг бизнесийн зээл, 39 хувийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. Шинээр олгосон зээлийн жилийн өсөлт 2025 оны 1 дүгээр улиралд бизнесийн зээлийн хувьд 28.6 хувьд хүрч, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 15.8 нэгж хувиар саарлаа. Бизнесийн шинээр олгосон зээлийн өсөлтөд бөөний болон жижиглэн худалдаа, санхүү болон даатгалын үйл ажиллагаа, барилга, уул уурхайн салбаруудад зээл олголт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Харин шинээр олгосон хэрэглээний зээлийн өсөлт 2025 оны 1 дүгээр улиралд 22.3 хувьд хүрч, өсөлтийн хурд 4.8 нэгж хувиар саарчээ. Шинээр олгосон хэрэглээний зээлийн өсөлтөд цалин, тэтгэврийн болон хадгаламж барьцаалсан зээл голчлон нөлөөллөө. Төв банк 2025 оны 3 дугаар сард шинээр олгох хэрэглээний зээлийн хувьд мөрдөгдөх өр ба орлогын харьцааг 50 хувь болгон шинэчилж, тэтгэвэр, тэтгэмж барьцаалсан зээлд сарын төлбөрөө төлсний дараах зээлдэгчийн үлдэх орлого нь хүн амын амьжиргааны доод түвшнээс доошгүй байхаар тогтоох шийдвэрийг гаргаж, хэрэглээний зээлийн нөхцөлийг чангарууллаа.

55. Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ тогтвортой буурсан хэдий ч өмнөх улирлаас өслөө. Чанаргүй зээлийн нийт хэмжээ 2025 оны 1

дүгээр улирлын байдлаар 2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар буурсан боловч өмнөх улирлаас 9.4 хувиар өсжээ. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 5.3 хувь байна. Чанаргүй зээлийн 17.8 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 16.3 хувийг барилга, 14.6 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, 14.4 хувийг цалин, 12.3 хувийг уул уурхай, олборлолтын зээл бүрдүүлж байна. Банкны салбарын зээлийн чанар өмнөх улирлаас муудахад цалин болон бөөний болон жижиглэн худалдааны зээл голлон нөлөөлөв.

56. Иргэдийн төгрөгийн хадгаламжийн өсөлт өндөр хэвээр байна. Банкнуудын нийт хадгаламж 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 26.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19.7 хувиар өслөө. Үүнээс иргэдийн хадгаламж 22.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 20.6 хувиар өссөн байна. Тодруулбал, иргэдийн төгрөгийн хадгаламж 19.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 25.4 хувиар өссөн бол иргэдийн валютын хадгаламж 3.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар өслөө. Харин байгууллагын нийт хадгаламж 4.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар өслөө. Байгууллагын төгрөгийн хадгаламж 3.0 их наяд болж, өмнөх оны мөн үеэс 5.4 хувиар, валютын хадгаламж 1.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 43.2 хувиар өссөн байна. Төгрөгийн

Зураг 3.5. Хадгаламжийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн үзүүлэлтүүд



Тэмдэглэл: Бодит үйлчилж буй хүү=(1+Зарласан хүүгийн хувь/хүү бодох давтамж)^(Хүү бодох давтамж)-1

хадгаламжийн үлдэгдэлд жигнэсэн дундаж хүү 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 11.8 хувь байгаа бол валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 4.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.1 ба 0.4 нэгж хувиар тус тус өсжээ. Иргэдийн төгрөгийн хадгаламжийн өсөлтөд өрхийн бодит орлогын өсөлт гол нөлөө үзүүлээ.

57. Активын долларжилтын түвшин өмнөх оны мөн үеэс буурлаа. Мөнгөний нийлүүлэлтэд эзлэх гадаад валютын харилцах ба хадгаламжийн хэмжээ 2025 оны 1 дүгээр улиралд 22.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.1 нэгж хувиар буурсан байна. Активын долларжилтын түвшин буурахад гадаад валютын харилцах өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар буурсан нь нөлөөлжээ.

58. Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү өсөв. Мөнгөний бодлогын хүү 2025 оны 3 дугаар сард 2 нэгж хувиар өсөж, 12 хувьд хүрсэн. Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2025 оны 1 дүгээр улиралд 11.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар буурсан бол өмнөх улирлаас 2 нэгж хувиар өссөн байна.

59. Зээл болон хадгаламжийн бодит үйлчилж буй хүүгийн зөрүү 2025 оны 1 дүгээр улиралд өслөө. Арилжааны банкнуудын бодит үйлчилж буй зээлийн хүү 2025 оны 1 дүгээр улиралд 17.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.4 нэгж хувиар өсжээ. Харин бодит үйлчилж буй хадгаламжийн хүү 12.0 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.4 нэгж хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Зээл ба хадгаламжийн бодит үйлчилж буй хүүгийн зөрүү өмнөх оноос 0.6 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.9 нэгж хувиар өсөв. Бодит үйлчилж буй хүүгийн зөрүү нэмэгдэхэд мөнгөний бодлогын хүү 2 нэгж хувиар өссөн нь нөлөөллөө.

60. Зээлийн тэлэлт сэргэх хандлагатай байна. 2024 оны 4 дүгээр улиралд нийт зээл дотоодын нийт бүтээгдэхүүний 45.9 хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.8 нэгж хувиар өссөн

байна. Зээлийн тэлэлт 2022-2023 онд саарсан байсан бол 2024 онд эдийн засгийн идэвхжилийн нөлөөгөөр сэргэж эхэллээ. Мөн банкны салбарын нийт зээл ба хадгаламжийн харьцаа 2025 оны 1 дүгээр улиралд 1.44 болж, өмнөх оны мөн үеэс 0.15 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.05 нэгж хувиар тус тус өсжээ. Уг харьцаа өсөхөд банкны салбарын зээлийн өндөр өсөлт болон банкнуудын ашигт ажиллагаа сайжирсан нь нөлөөлсөн байна. Зээл ба хадгаламжийн харьцаа хэт өндөр болсноор хөрвөх чадварын эрсдэлийг нэмэгдүүлж байна.

61. Банкны салбарын ашигт ажиллагаа тогтвортой түвшинд хадгалагдаж байна. Банкны салбарын активын өгөөж 2025 оны 1 дүгээр улиралд 2.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар буурлаа. Хэдийгээр банкны салбарын активын өгөөж өмнөх оны мөн үеэс буурсан ч 2 хувиас дээш хадгалагдаж байгаа нь банкнуудын ашигт ажиллагаа өндөр байгааг илтгэж байна. Банкнуудын ашигт ажиллагаа сайжрахад эх үүсвэр талаас төгрөгийн хадгаламж нэмэгдсэн болон зээлийн чанар сайжирсан нь голлох нөлөө үзүүлээ.

62. Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үлдэгдлийн өсөлт өндөр хэвээр байна. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 575 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийт зээлийн хэмжээ 6.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 55.1 хувиар өссөн байна. Нийт олгосон зээлийн 94.1 хувийг иргэдэд, 5.9 хувийг хуулийн этгээдэд олгосон зээл бүрдүүлжээ. 2025 оны 1 дүгээр улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээлдэгчдийн 88.7 хувь буюу 2.3 сая харилцагч финтек зээлийн үйлчилгээгээр 1.8 их наяд төгрөгийн зээл авсан байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жинлэсэн дундаж хүү сарын 3.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар буурчээ.

Хүснэгт 3. Санхүүгийн салбарын эмзэг байдал

		Зээлийн тэлэлт	Хөрөнгийн чанар	Ашигт ажиллагаа	Төлбөр гүйцэтгэх чадвар	Хөрвөх чадвар
		Нийт зээл/ДНБ (%)	Чанаргүй зээл/Нийт зээл (%)	Банкны активын өгөөж (%)	Зээл/Хадгаламж (%)	Хөрвөх актив/Богино хугацаат өр төлбөр (%)
2020	I	44.8	10.8	0.3	123	56.4
	II	45.4	11.1	1.2	114	47.6
	III	45.4	11.4	1	104	46.7
	IV	45	11.8	0.5	95	57.6
2021	I	39.1	11.5	1.1	95	56.6
	II	42.4	10.3	2.2	100	61.6
	III	44.8	9.9	1.5	105	55.2
	IV	46.2	10	0.7	110	60.5
2022	I	39.9	9.7	2	123	49.8
	II	42.4	9	3.5	128	50.6
	III	41.5	11.2	1.3	134	47.5
	IV	40.1	9.2	2.8	127	64.2
2023	I	32.3	9.6	2.4	122	54.3
	II	35.6	8.7	2.7	131	55.4
	III	36.3	8.5	2.4	131	57.9
	IV	38.1	7.5	2.6	124	68
2024	I	36.1	7.1	2.8	129	66.3
	II	41.5	5.9	3.4	139	62.8
	III	43.7	5.7	2.3	141	60.1
	IV	45.9	5.1	2.6	139	66.9
2025	I	-	5.3	2.4	144	63.7

Тэмдэглэл: Хөрвөх активыг касс дахь бэлэн мөнгө, төв банк дахь харилцах ба хадгаламж, төв банкны үнэт цаасны нийлбэрээр тооцов.

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Бүлэг 4

ГАДААД СЕКТОР

4.1. Гадаад худалдаа

4.2. Төлбөрийн тэнцэл, гадаад өр

4. ГАДААД СЕКТОР

ТОЙМ

Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр зэрэг голлох уул уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээ өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагдсан хэдий ч нүүрсний үнэ буурсан нь экспортын орлогын өсөлтийг хязгаарлалаа. Импортын өсөлт саарсан ч экспортын орох урсгал буурснаар урсгал дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 1.8 дахин тэллээ.

4.1. Гадаад худалдаа

63. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан хэдий ч худалдаа эргэлт өмнөх оны мөн үеэс буурлаа. Монгол Улс 2025 оны эхний улирлын байдлаар дэлхийн 123 улстай худалдаа хийж, худалдааны тэнцэл 465 сая ам.долларын ашигтай гарсан хэдий ч нийт бараа эргэлт 5.6 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар буурлаа.

64. Экспортын орлогын өсөлт саарлаа. 2025 оны эхний улирлын байдлаар Монгол Улсын экспорт 3.0 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 17.7 хувиар буурсан байна. Энэ бууралтад нүүрсний экспортын биет хэмжээ болон олон улсын зах зээл дээрх нүүрсний үнийн уналт голлон нөлөөлжээ. Цаашид экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ өндөр түвшинд тогтвортой хадгалагдах төлөвтэй байгаа хэдий ч зэсийн баяжмалаас бусад голлох бүтээгдэхүүний хилийн үнэ гадаад орчны нөлөөгөөр буурахаар хүлээгдэж байна.

65. Гадаад орчноос шалтгаалан нүүрсний экспортын биет хэмжээ болон үнэ буурлаа. БНХАУ-ын цагаан сарын баярын амралтаас үүдэн тус улсын гангийн томоохон үйлдвэрүүд коксжих нүүрсний татан авалтаа удаашруулсан нь манай улсын нүүрсний экспортод сөргөөр нөлөөллөө. Үүний үр дүнд 2025 оны нэгдүгээр улиралд нүүрсний экспорт 17.5 сая тоннд хүрч,

өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.3 хувиар буурсан байна. Мөн хилийн үнэ өмнөх оны мөн үеэс 38 хувиар буурснаар нүүрсний экспортын орлого 40 хувиар буурч, нийт экспортын өсөлтөд сөрөг нөлөө үзүүллээ. Цаашид, гадаад орчин дэх нүүрсний эрэлт тогтвортой байж биет хэмжээ нэмэгдэх хэдий ч хилийн үнэ сэргэх төлөвгүй байна.

66. Зэсийн баяжмалаас бусад голлох бүтээгдэхүүний экспортын хэмжээ буурлаа. 2025 оны эхний улирлын байдлаар зэсийн баяжмалын экспорт 456 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь далд уурхайн олборлолтын үйл ажиллагаа тогтворжсон болон дэлхийн зах зээл дэх зэсийн эрэлт өндөр түвшинд хадгалагдаж байгаагаас шалтгааллаа. Харин БНХАУ дахь гангийн дотоод үйлдвэрлэл илүүдэлтэй байгаагаас гадна олон улсын худалдаанд тодорхой бус байдал үүсгэж буй тарифын бодлого, худалдааны зөрчлүүдийн нөлөөгөөр төмрийн хүдрийн экспортын хэмжээ 1.77 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 2 хувиар, газрын тосны экспорт 915 мянган тоннд хүрч, 12.9 хувиар тус тус буурсан байна. Цаашид зэсийн баяжмал болон төмрийн хүдрийн олборлолт тогтвортой нэмэгдэх төлөвтэй бөгөөд цэвэр зэсийн дэлхийн зах зээл дэх үнэ өсөх хандлагатай байна.

Зураг 4.1. Экспорт



67. Экспортын хоригоос шалтгаалан зарим малын гаралтай бүтээгдэхүүний экспорт буурлаа. Угаасан ноолуурын экспортыг хориглох Засгийн газрын шийдвэрийн хүрээнд 2025 оны эхний улирлын байдлаар ноолуурын экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34 хувиар буурсан байна. Мөн боловсруулах үйлдвэрлэлийн идэвх сул байсантай холбоотойгоор махны экспорт 45 хувиар, арьс ширний экспорт 75 хувиар тус тус буурчээ.

68. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны идэвх суларлаа. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2025 оны эхний улирлын байдлаар 678 мянган тонн нүүрсийг 56 мянган ам.доллараар, 2,073 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 125 сая ам.доллараар, 4.5 мянган тонн зэсийн баяжмалыг 9 сая ам.доллараар, 11.6 мянган тонн хайлуур жоншны хүдэр, баяжмалыг 3.0 сая ам.доллараар тус тус арилжаалаад байна. 2024 оны хоёрдугаар улиралд уул уурхайн бүтээгдэхүүний биржээр нийт 212 арилжаа амжилттай хийгдсэн бол гуравдугаар улирлаас эхлэн арилжааны идэвх тасралтгүй буурсаар 2025 оны нэгдүгээр улиралд 94 арилжаа болж, огцом буурлаа.

69. Импортын өсөлтийн хурд саарлаа. 2024 онд эдийн засгийн идэвхжил өндөр байж, өрхийн орлого, зээл олголт нэмэгдсэнээр иргэд, аж ахуй нэгжийн худалдан авах чадвар сайжирч импортын бараа, бүтээгдэхүүний урсгал өндөр байв. Харин 2025 оны эхний улирлын байдлаар импорт өмнөх оны мөн үеэс 134 сая ам.доллар буюу 5.5 хувиар өсөж, өсөлтийн хурд саараад байна.

70. Импортын өсөлтийг барааны бүлгээр авч үзвэл: нийт импортын өсөлт хэрэглээний бүтээгдэхүүн 6.6 нэгж хувь, хөрөнгө оруулалтын зориулалттай машин механик тоног төхөөрөмж, барилгын материал 0.3 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн бол аж үйлдвэрийн орц 1.4 нэгж хувийн сөрөг нөлөөг үзүүлсэн байна.

71. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өндөр хэвээр байна. Хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлтөд суудлын автомашин болон хүнсний бүтээгдэхүүний импорт голлох нөлөөг үзүүллээ. Суудлын машины импорт 325 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 29 хувиар өслөө. 2025 оны 6 сарын 1-ны өдрөөс эхлэн 10-аас дээш жилийн насжилттай тээврийн хэрэгсэлд шинээр улсын дугаар олгохгүй байх Нийслэлийн засаг даргын захирамж гарсан. Нийт импортолж буй суудлын автомашины 50 орчим хувь нь 10-аас дээш жилийн насжилттай байдаг бөгөөд уг шийдвэр мөрдөгдөж эхлэх хүртэл суудлын автомашины импорт өндөр хадгалагдахаар байна. Мөн 2025 оны эхний улирлын байдлаар өрхийн хүнсний хэрэглээ 16 хувиар нэмэгдсэнээр хүнсний бүтээгдэхүүний импорт 14 хувиар өсөж 254 сая ам.долларт хүрлээ.


72. Төслүүдийн бүтээн байгуулалтын ажил эрчимжиж, барилгын материалын импорт өслөө. Оны эхний улирлын байдлаар барилгын материалын импорт 230 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 18.6 хувиар өссөн байна. Мөн Эрдэнэбүрэн УЦС, Газрын тосны үйлдвэр, Сэлбэ дэд төв, Туулийн хурдны зам зэрэг томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр энд онд барилгын материалын импортын өсөлт өндөр хадгалагдахаар байна.

73. Худалдааны гол түнш орнуудын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт саарснаар импортын барааны зардал бага түвшинд байв. Импортын дүн өмнөх оны мөн үеэс 133 сая ам.доллараар өссөний 88 орчим хувийг тоо хэмжээ, 12 орчим хувийг үнийн өсөлт бүрдүүлсэн байна (Зураг 4.2). Худалдааны гол түнш орнуудын үнийн өсөлт саарснаар импортын барааны үнийн өсөлт бага түвшинд байв. Тухайлбал, манай улсын нийт импортын 40 хувийг бүрдүүлж буй БНХАУ-ын инфляц 2025 оны эхний улиралд дунджаар -0.1 хувь байв. Харин нийт импортын 25 хувийг бүрдүүлж буй ОХУ-ын инфляц 2025 оны эхний улиралд


дунджаар 10.2 хувь байв. Гэвч тус улсаас импортолж буй бүтээгдэхүүний 70 хувийг нефтийн бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа ба үүний 21 нэгж хувийг АИ-92 автобензин, 45 нэгж хувийг дизелийн түлш бүрдүүлж байна. ОХУ-ын Роснефть компанитай 2022 онд байгуулсан

Зураг 4.2. Импорт

1.Импортын жилийн өсөлт
(нэгж хувь)



2.Импортын өөрчлөлт
(сая ам.доллар)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

3.Импортын голлох бүтээгдэхүүн
(сая ам.доллар)

Бүтээгдэхүүн	2024.03	2025.03	Өсөлт
Хүнс	223	254	13.8%
Суудлын автомашин	252	325	28.9%
Ачааны машин	125	143	14.7%
Барилгын материал	194	230	18.6%
Тоног төхөөрөмж	421	457	8.6%
Шатахуун	504	519	3.0%
Нийт	2,414	2,548	5.5%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

4.2. Төлбөрийн тэнцэл, гадаад өр

74. Экспортын бууралтын голлох нөлөөгөөр урсгал дансны алдагдал нэмэгдлээ. Үйлчилгээний данс болон гадаад зээл, бондын хүүгийн төлбөрийг багтаадаг анхдагч орлогын дансны алдагдал 2025 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс буурсан сайн үзүүлэлттэй гарсан ч барааны экспортын бууралт 579 сая ам.долларт хүрснээр урсгал данс 2025 оны эхний улиралд 959 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 422 сая ам.доллараар өслөө. Барааны экспорт 2025 оны 3 дугаар сард өмнөх оноос 519 сая ам.доллараар бага байсан нь эхний улирлын экспортын бууралтын дийлэнхийг бүрдүүллээ.


75. Бизнесийн болон барилгын ажил үйлчилгээний төлбөр буурсан нь үйлчилгээний дансны алдагдал буурахад нөлөөллөө. Монгол Улс 1,194 сая ам.долларыг үйлчилгээний зардалд төлж, 318 сая ам.долларын үйлчилгээний орлогыг олсноор үйлчилгээний дансны алдагдал үйлчилгээний дансны алдагдал 2025 оны эхний улиралд 876 сая ам.долларт хүрч, алдагдал өмнөх оны мөн үеэс 168 сая ам.доллараар буурлаа. Нийт үйлчилгээний дансны алдагдал буурахад бизнесийн бусад үйлчилгээний зардал өмнөх оны мөн үеэс 82 сая ам.доллараар, барилга, барилгын ажил үйлчилгээний зардал 85 сая ам.доллараар тус тус буурсан нь голлон нөлөөллөө.

76. Зорчигч тээвэр болон ачаа тээврийн орлого нэмэгдэж, тээврийн үйлчилгээний алдагдал буурлаа. Тээврийн үйлчилгээ нийт үйлчилгээний зардлын 31 хувийг, үйлчилгээний орлогын 48 хувийг бүрдүүллээ. Зорчигч тээврийн үйлчилгээний орлого өмнөх оны мөн үеэс 14 сая ам.доллараар, ачаа тээврийн үйлчилгээний орлого өмнөх оны мөн үеэс 11 сая ам.доллараар нэмэгдсэнээр нийт тээврийн үйлчилгээний дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 3 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.


77. Хувийн журмаар болон жуулчлалын зорилгоор гадаадад зорчсон иргэдийн тоо буурч, аялал жуулчлалын үйлчилгээний зардлын өсөлт саарлаа. Аялал жуулчлалын үйлчилгээ нийт үйлчилгээний зардлын 42 хувийг, үйлчилгээний орлогын 26 хувийг тус тус бүрдүүллээ. 2025 оны эхний улирлын байдлаар аяллын үйлчилгээний орлого өмнөх оны мөн үеэс 15 хувиар, зардал 8 хувиар тус тус өссөн байна. Аялал жуулчлалын үйлчилгээний зардлын жилийн өсөлт өмнөх оны эхний улиралд 125 сая ам.доллар буюу 37 хувь байсан бол энэ оны эхний улиралд 35 сая ам.доллар буюу 7 хувьд хүрч саарлаа. Хувийн журмаар болон жуулчлалын зорилгоор гадаадад зорчсон Монгол иргэдийн тоо 2024 оны эхний улиралд өмнөх оноос 2.1 дахин өсөж байсан бол энэ оны

Зураг 4.3. Урсгал болон санхүүгийн дансны тэнцэл, төгрөгийн ханш


1. Урсгал дансны тэнцэл
(сая ам.доллар)



2. Санхүүгийн дансны тэнцэл
(сая ам.доллар)



3. Төгрөгийн ханшийн индексийн өөрчлөлт
(хувь)



эхний улиралд өмнөх оны мөн үеэс 148 мянгаар буюу 35 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

78. Уул уурхайн салбарын шууд хөрөнгө оруулалт бууралтын голлон нөлөөгөөр санхүүгийн дансны ашиг буурлаа. Засгийн газар болон арилжааны банкнууд шинээр гадаад бонд гаргасан хэдий ч шууд хөрөнгө оруулалтын дүн буурснаас шалтгаалан санхүүгийн дансны ашиг 2025 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 157 сая ам.доллараар буурлаа. Тухайлбал, 2025 оны эхний улиралд Монгол Улсад 666 сая сам.долларын шууд хөрөнгө оруулалт орсон нь өмнөх оны мөн үеэс 34 хувиар буюу 342 сая ам.доллараар бага дүн байв. Салбараар авч

80. Гадаад валютын нөөц буурч, төгрөгийн ам.доллартой харьцах ханш суларлаа. Гадаад валютын улсын нөөц 2025 оны эхний улирлын эцэст 4,996 сая ам.долларт хүрч, өмнөх оны эцсээс 514 сая ам.доллараар буурлаа. Монголбанк 2025 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 689 сая ам.доллараар буюу 56.8 хувиар их нийт 1,902 сая ам.долларыг зах зээлд дуудлага худалдаагаар нийлүүлээ. Төгрөгийн ам.доллартой харьцах албан ханш 2025 оны эхний улирлын эцэст 3,488 төгрөгт хүрч, оны эхнээс 67 төгрөгөөр суларлаа. Худалдааны түнш орнуудын валютаар жигнэсэн төгрөгийн нэрлэсэн ханшийн индекс 2025 оны эхний улирлын эцэст өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар суларсан бол үнийн өөрчлөлтийн нөлөөг хассан бодит ханшийн индекс өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар чангарлаа.

81. Нийт эдийн засгийн хадгаламж буурснаар урсгал дансны алдагдал тэллээ. Урсгал дансны тэнцлийг тухайн улсын нийт хадгаламж болон хөрөнгө оруулалтын зөрүүгээр мөн тайлбарладаг. Сүүлийн 10 жилийг авч үзвэл манай улсын хөрөнгө оруулалтын хэрэгцээ хадгаламжаас давж, 2023 оноос бусад онд урсгал данс алдагдалтай гарсан. Сүүлийн 4 улирлын нийлбэрээр тооцсон ДНБ-д харьцуулсан урсгал дансны алдагдал 2025 оны

үзвэл, уул уурхайн салбарын шууд хөрөнгө оруулалт 495 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 331 сая ам.доллар буюу 40 хувиар, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны шууд хөрөнгө оруулалт 45 сая ам.долларт, хүрч өмнөх оны мөн үеэс 40 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин худалдааны салбарын шууд хөрөнгө оруулалт 14 сая ам.доллараар өсөж, 61 сая ам.долларт хүрсэн байна. Бусад 18 салбарын нийт шууд хөрөнгө оруулалтын дүн 64 сая ам.долларт хүрч,

79. өмнөх оны мөн үеэс ердөө 5 сая ам.доллараар өссөн байна. 2025

эхний улиралд 12 хувьтай тэнцэж, өмнөх оны мөн үеэс 8.6 нэгж хувиар нэмэгдлээ. Үүнд хэрэглээний өсөлтөөс шалтгаалсан нийт орлогоос хэрэглээнд зарцуулсны дараа үлдэх ДНБ-д харьцуулсан хадгаламжийн хувь хэмжээ өмнөх оны мөн үеэс 8.1 нэгж хувиар өссөн нь голлон нөлөөллөө. Нийт эдийн засгийг төр болон хувийн хэвшилд хуваан харвал, Засгийн газрын хадгаламж буурч, хөрөнгө оруулалтын хэрэгцээ нэмэгдсэн бол хувийн хэвшлийн хадгаламж, хөрөнгө оруулалт буурсан байна.

82. Гадаад хөрөнгө оруулалтын позиц сул хэвээр байна. Гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгө болон Монгол Улс бусад улсад төлөх үүрэг бүхий өр төлбөрийн зөрүүг харуулдаг гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2025 оны эхний улиралд -45.2 тэрбум ам.долларт хүрч, ДНБ-ий -186 хувьтай тэнцэж байна. 2025 оны эхний улирлын байдлаар Монгол улсад байршиж буй гадаад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн дүн 54.5 тэрбум ам.долларт хүрсэн нь гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгөөс 5.8 дахин их байна. Гадаад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн 62 хувь буюу 33.9 тэрбум ам.долларыг шууд хөрөнгө оруулалт, 26 хувь буюу 14.1 тэрбум ам.долларыг зээл бүрдүүлж байна. Харин гадаад улсад

байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн 53 хувь буюу 5.0 тэрбум ам.доллар нь нөөц хөрөнгө байна. Шууд хөрөнгө оруулалтыг хассан дүнгээр тооцсон гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2025 оны эхний улиралд ДНБ-ий -51 хувьтай тэнцэж байна. Цаашид урсгал дансны алдагдлыг хязгаарлах, гадаад валютын нөөцийг зузаатгах замаар гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позицыг сайжруулж, гадаад шокт өртөх эмзэг байдлыг бууруулах шаардлагатай.

83. Нийт гадаад өрийн үлдэгдлийн дүн өслөө. Засгийн газар, төв банк болон хувийн хэвшлийн гадаад зах зээлээс татсан эх үүсвэр нэмэгдэж, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2025 оны эхний улирлын эцэст 38.0 тэрбум ам.доллар болж, өмнөх улирлаас 0.8 тэрбум ам.доллараар буюу 2.2 хувиар өслөө. Энэ нь ДНБ-ий 157 хувьтай тэнцэж байна.

84. Хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдлийн өсөлтийн дийлэнхийг санхүү болон уул уурхайн салбар бүрдүүлээ. Хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдэл 2025 оны эхний улиралд өмнөх улирлаас 456 сая ам.доллараар өслөө. Үүнд санхүү болон даатгалын салбарын гадаад өр өмнөх улирлаас 271 сая ам.доллараар, уул уурхайн салбарын гадаад өр өмнөх улирлаас 249 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөллөө.

85. Улсын нийт гадаад өрийн дийлэнхийг шууд хөрөнгө оруулалт болон зээл бүрдүүлж байна. Нийт гадаад өрийн үлдэгдлийн 46 хувь буюу 17.6 тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалттай компанийн өглөг, 37 хувь буюу 14.1 тэрбум ам.доллар нь зээл байна. Зээлийн үлдэгдлийн 55 хувь нь Засгийн газар болон төв банкны зээл, 45 хувь нь хувийн хэвшлийн зээл байна. Цаашид макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, зээлжих зэрэглэлийг үргэлжлүүлэн ахиулж, гадаад санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, өртгийг бууруулах шаардлагатай.

86. Гадаад өрийн динамик дунд хугацаанд харьцангуй тогтвортой байгаа ч ханш, урсгал дансны тэнцлийн шокуудад эмзэг байна. Суурь төсөөллөөр экспорт болон ДНБ-ий өсөлтийн эерэг нөлөөгөөр ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ дунд хугацаанд тогтвортой буурахаар байна. Гэсэн хэдий ч ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ ханшийн өөрчлөлт, урсгал дансны тэнцлийн шокуудад эмзэг байна. Суурь төсөөлөлтэй харьцуулахад гадаад өр болон ДНБ-ий харьцаа 2025-2026 онд урсгал дансны үндсэн тэнцэл 1 стандарт хазайлтаар буурахад 10.7 нэгж хувиар, төгрөгийн ханш 10 хувиар сулрахад 16.7 нэгж хувиар тус тус өсөхөөр байна


Зураг 4.4. Урсгал данс, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад өр

1.Урсгал дансны тэнцэл
(ДНБ-д эзлэх хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол,
Монголбанкны статистик

2.Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц
(ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол,
Монголбанкны статистик

3.Гадаад өрийн улирлын өөрчлөлт
(сая ам.доллар)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол,
Монголбанкны статистик

Тэмдэглэл: ДНБ-д эзлэх хувийг 4 улирлын нийлбэрээр тооцов.


Зураг 4.55. Гадаад өрийн тогтвортой байдал

ГАДААД ӨР												
(өөрөөр тэмдэглээгүй бол ДНБ-д эзлэх хувиар)												
	Гүйцэтгэл							Төсөөлөл				Өр тогтворжуулах урсгал дансны үндсэн тэнцэл
	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	
Гадаад өр: Суурь төсөөлөл	217.9	216.1	243.1	221.1	194.4	170.1	157.9	160.6	162.6	166.3	164.9	-7.6
Гадаад өрийн өөрчлөлт	-21.5	-1.7	26.9	-21.9	-26.7	-24.3	-12.2	2.8	2.0	3.7	-1.4	
Өр үүсгэх урсгалууд	-20.9	-8.4	14.9	-25.2	-11.4	-32.2	-16.3	-5.7	-3.4	-0.5	-1.5	
Урсгал дансны алдагдал, хүүгийн төлбөрийг хассанаар	7.7	5.5	-4.9	5.6	4.9	-10.9	-1.3	1.1	2.3	3.7	6.2	
Өрийн бус хөрөнгийн цэвэр орох урсгал (-)	-6.9	-7.8	-4.6	-7.6	-0.8	-1.2	-2.0	-2.3	-1.9	-1.6	-1.4	
Өрийн автомат динамик 1/	-21.8	-6.0	24.4	-23.2	-15.6	-20.1	-12.9	-4.5	-3.9	-2.6	-6.3	
Нэрлэсэн хүүгийн түвшний нөлөө	9.0	9.7	10.0	8.2	8.5	10.3	10.6	10.2	9.4	8.7	7.5	
Бодит ДНБ-ий өсөлтийн нөлөө	-16.2	-11.3	10.5	-3.5	-9.9	-12.2	-7.1	-10.8	-8.9	-9.8	-9.8	
Үнэ, валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	-14.7	-4.5	3.9	-27.9	-14.2	-18.2	-16.4	-3.9	-4.4	-1.5	-3.9	
Бусад	-0.6	6.6	12.1	3.2	-15.3	7.9	4.1	8.4	5.3	4.2	0.1	
Гадаад өр-экспорт харьцаа (хувь)	374.5	364.8	423.3	377.7	303.4	223.0	228.2	233.4	242.9	258.6	268.4	
Гадаад өр: Гол хувьсагчид түүхэн дундаж түвшинд байх үед 2/								160.2	159.4	157.4	151.2	-6.6
								түүхэн дундаж	стандарт хазайлт			
Бодит ДНБ-ий өсөлт (хувь)	7.7	5.6	-4.6	1.6	5.0	7.4	4.9	3.7	3.6			
Нэрлэсэн гадаад хүү (хувь)	4.3	4.8	4.3	3.9	4.3	6.3	7.2	4.8	1.1			
Экспортын өсөлт (ам.доллараарх, хувь)	12.8	9.7	-9.1	17.1	22.8	41.1	5.3	11.4	16.1			
Импортын өсөлт (ам.доллараарх, хувь)	37.5	3.1	-20.6	26.1	30.9	11.8	21.3	10.6	20.9			
Урсгал дансны тэнцэл, хүүгийн төлбөр хассанаар	-7.7	-5.5	4.9	-5.6	-4.9	10.9	1.3	-0.4	5.7			
Өрийн бус хөрөнгийн цэвэр орох урсгал	6.9	7.8	4.6	7.6	0.8	1.2	2.0	3.5	3.9			


1/ДНБ, гадаад өрийн хүү, ханш зэрэг үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөс шалтгаалах гадаад өрийн хэлбэлзэл

2/Гол хувьсагчид буюу урсгал дансны үндсэн тэнцэл, өрийн бус хөрөнгийн цэвэр орох урсгал, бодит ДНБ-ий жилийн өөрчлөлт, ДНБ-ий дефлятор, нэрлэсэн гадаад хүүний үзүүлэлтүүд сүүлийн 10 жилийн түүхэн дундажтай тэнцүү байхаар тооцов.


1. Суурь болон түүхэн дундаж хувилбар



2. Хүүгийн шок



3. ДНБ-ий өсөлтийн шок




4. Урсгал дансны үндсэн тэнцлийн шок




5. Хавсарсан шок

(хүү, урсгал данс, ДНБ-ий өсөлт)



6. Ханшийн шок



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Түүхэн дундаж, стандарт хазайлтыг сүүлийн 10 жилийн үзүүлэлтээр тооцов. Урсгал данс, ДНБ-ий өсөлтийн шокийг 1 стандарт хазайлтаар, хүүгийн шокийг суурь түвшнээс 1 нэгж хувиар өсөхөөр, ханшийн шокийг 10 хувийн сулралтаар 2025-2026 оны хувьд тус тус тооцов.

Бүлэг 5

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

5.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал

5.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага


5.3. Олон улсад 2025 онд зарлагдсан индексүүд

5. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ ТОЙМ

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2024 онд 3.3 хувьд хүрсэн хэдий ч геополитикийн тогтворгүй байдал, худалдааны дайны өрнөлтэй холбоотойгоор дэлхийн дахинд тодорхой бус байдал нэмэгдэв.

5.1. Дэлхийн эдийн засаг

87. Худалдааны дайнтай холбоотойгоор дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдлээ. Геополитикийн тогтворгүй байдал, худалдааны дайны нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхийн тодорхой бус байдлын индекс (World Uncertainty Index) түүхэн дээд түвшинд хүрлээ. Үүнтэй холбоотойгоор ОУВС 2025 оны 4 дүгээр сард дэлхийн эдийн засгийн 2025 оны өсөлтийн төсөөллийг 3.3 хувиас 2.8 хувь, 2026 оны өсөлтийн төсөөллийг 3.3 хувиас 3.0 хувь болгож, 2025 оны 1 дүгээр сард зарласан төсөөллөөс тус тус 0.5 нэгж болон 0.3 нэгж хувиар бууруулаад байна. Мөн Дэлхийн банк 2025 оны 6 дугаар сард 2025 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 2.7 хувиас 2.3 хувь болгож, 2026 оны өсөлтийн төсөөллийг 2.7 хувиас 2.4 хувь болгон тус тус бууруулаад байна.



88. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарав. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2025 оны эхний улиралд 5.4 хувь гарч, тус улсын засгийн газрын зорилтот түвшинд хүрсэн хэдий ч үл хөдлөх хөрөнгийн салбар уналттай, дотоод эрэлт сул хэвээр байгаа нь эдийн засгийн идэвхжилийг

хязгаарлаж байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг ОУВС 2025 болон 2026 онд 4 хувь байх төсөөллийг 2025 оны 4 дүгээр сард зарлаад байна. Гэсэн хэдий ч худалдааны дайнтай холбоотой тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа нь БНХАУ-ын эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж байна.

89. Евро бүсийн эдийн засаг 2024 онд 0.8 хувиар тэллээ. Евро бүсийн эдийн засаг 2024 онд 0.8 хувиар, 2025 оны эхний улиралд 0.3 хувиар өслөө. Бүсийн эдийн засгийн 30 орчим хувийг бүрдүүлдэг ХБНГУ-ын аж үйлдвэрийн салбарын идэвхжил сул хэвээр байгаа нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж байна. Худалдааны дайнтай холбоотойгоор эдийн засгийн өсөлт 2025 онд 0.8 хувьд хадгалагдах бол 2026 онд бодит цалингийн өсөлт, ХБНГУ-ын төсвийн тэлэлтийн нөлөөгөөр бүсийн өсөлт 1.2 хувьд хүрч эрчимжинэ гэж ОУВС тооцоолж байна.

90. Хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр АНУ-ын эдийн засаг 2024 онд 2.8 хувиар тэлсэн бол импортын өсөлтийн нөлөөгөөр 2025 оны эхний улиралд 0.2 хувиар агшлаа. Худалдааны дайн, бодлогын тодорхой бус байдал болон эрэлт буурах төлөвөөс шалтгаалан ОУВС тус улсын эдийн засгийн 2025 оны өсөлтийн төсөөллийг 1.8 хувь, 2026 оны өсөлтийн төсөөллийг 1.7 хувь болгож, өмнөх төсөөллөөс тус тус 0.9 нэгж хувь болон 0.4 нэгж хувиар бууруулаад байна. Тус улсын өрнүүлж буй худалдааны дайны цар хүрээ улам бүр нэмэгдэж байгаа нь АНУ төдийгүй дэлхийн худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал хумигдах, инфляц өсөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

5.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага

91. Лондоны металлын бирж дээрх цэвэр зэсийн дундаж үнэ 2025 оны эхний 5 сарын байдлаар цэвэр зэсийн дундаж үнэ 9,340 ам.доллар болж, өмнөх оноос 2.1 хувиар өссөн байна. АНУ-ын тарифын бодлоготой холбоотойгоор томоохон үйлдвэрүүд зэсийн нөөцөө нэмэгдүүлж эхэлсэн нь оны эхэнд үнэ өсөхөд нөлөөлсөн хэдий ч 4 дүгээр сар гараад тарифын бодлого хэрэгжиж эхэлснээр зэсийн үнэ сүүлийн 3 сарын доод түвшинд хүрч буураад байна. Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдэж байгаа хэдий ч цахилгаан автомашин, сэргээгдэх эрчим хүч, тоон өгөгдөл боловсруулах төвүүд, технологийн салбарын хурдацтай хөгжлөөс шалтгаалан зэсийн эрэлт нэмэгдэж үнэ өсөхөөр байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар зэсийн дундаж үнэ 2025 онд 9,200 ам.доллар, 2026 онд 9,700 ам.долларт хүрэхээр байна.

92. Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний дундаж үнэ 2025 оны эхний 5 сарын байдлаар 186 ам.доллар болж, өмнөх оноос 23.3 хувиар буурлаа. Дэлхийн коксжих нүүрсний хэрэглээний хоёрдогч томоохон хэрэглэгч болох Энэтхэг улс руу чиглэсэн гангийн нийлүүлэлт нэмэгдсэн, БНХАУ-ын цагаан сарын баярын амралтаас шалтгаалан ган хайлуулах томоохон үйлдвэрүүд коксжих нүүрсний татан авалтаа удаашруулсан зэрэг нь коксжих нүүрсний үнэ буурахад голлон нөлөөллөө. Дэлхийн тодорхой бус байдал, худалдааны дайнаас шалтгаалан нүүрсний үнэ буурах дарамтыг нэмэгдүүлж байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар коксжих нүүрсний дундаж үнэ 2025 онд 180 ам.доллар, 2026 онд 178 ам.долларт хүрч буурахаар байна. Монгол Улсын нүүрсний экспортын дундаж үнэ 2025-2026 онд 80 ам.доллар байхаар тооцоолж байна.

93. Лондоны металлын бирж дэх алтны дундаж үнэ 2025 оны эхний 5 сарын байдлаар 3,021 ам.доллар болж, өмнөх оноос 26.5 хувиар өссөн

байна. АНУ-ын Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ 2024 онд бууруулсан нь алтны эрэлтийг нэмэгдүүлж, үнэ өсөхөд нөлөөллөө. Дэлхийн тодорхой бус байдал нэмэгдэж байгаатай холбоотойгоор алтны үнэ үргэлжлэн өсөх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар алтны дундаж үнэ 2025 онд 2,900 ам.доллар, 2026 онд 2,600 ам.долларт хүрэхээр байна.

94. Төмрийн хүдрийн (62 хувийн агууламжтай) үнэ 2025 оны эхний 5 сарын байдлаар 101 ам.доллар болж, өмнөх оноос 7.9 хувиар буурлаа. Австрали, Бразил зэрэг улсуудын нийлүүлэлтийн өсөлт, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт төмрийн хүдрийн үнэ буурахад голлон нөлөөллөө. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар богино хугацаанд сэргэх төлөвгүй байгаагаас гадна Австрали, Бразил зэрэг улсуудын олборлолт тогтвортой өсөхөөр байгаа тул төмрийн хүдрийн үнэ буурах төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар төмрийн хүдрийн дундаж үнэ 2025 онд 95 ам.доллар, 2026 онд 90 ам.долларт хүрэхээр байна. Монгол Улсын төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 2025 онд 72 ам.доллар, 2026 онд 69 ам.доллар байхаар тооцоолж байна.

95. Брент төрлийн газрын тосны дундаж үнэ 2025 оны эхний 5 сарын байдлаар 69 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 7.9 хувиар буурлаа. АНУ болон Канад, Бразил зэрэг улсуудын газрын тосны олборлолт нэмэгдсэнээс гадна БНХАУ-ын эрэлт бага байсан нь газрын тосны үнэ буурахад голлон нөлөөллөө. Геополитикийн тодорхой бус байдал, худалдааны дайнаас үүдэлтэй дэлхийн эдийн засгийн удаашралаас шалтгаалан газрын тосны үнэ буурах төлөвтэй. Олон улсын шинжээчдийн таамаглалаар Брент төрлийн газрын тосны дундаж үнэ 2025 онд 75 ам.доллар, 2026 онд 70 ам.долларт хүрэхээр байна. Монгол Улсын газрын тосны экспортын дундаж үнэ 2025

онд 75 ам.доллар, 2026 онд 72 ам.доллар
байхаар тооцоолж байна.

Зураг 5.2. Түүхий эдийн олон улсын зах зээл дэх үнэ

1. Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн гүйцэтгэл (\$/тонн)



Эх сурвалж: Блүүмберг

2. Зүүн хойд БНХАУ дахь 62 хувийн агууламжтай төмрийн
баяжмалын гүйцэтгэл (\$/тонн)



Эх сурвалж: Блүүмберг

3. Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих
нүүрсний гүйцэтгэл (\$/тонн)



Эх сурвалж: Блүүмберг

4. Брент газрын тосны гүйцэтгэл (\$/баррель)



Эх сурвалж: Блүүмберг

5.3. Олон улсад зарлагдсан индексүүд

96. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс:

Өв уламжлалын сангаас⁷ жил бүр тооцоолон гаргадаг Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр⁸ Монгол Улс 2025 онд дэлхийн 184 улсаас 74 дүгээрт эрэмбэлэгдэж өмнөх оноос 2 байр ахилаа.

Ингэснээр Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтэд Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр 2025 онд 75 дугаар байрт орох зорилтот түвшнийг давуулан биелүүлэв.

Хүснэгт 4. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ

Бүлэг	2024		2025	
	Оноо	Байр	Оноо	Байр
Хууль дээдлэх ёс	46.2	#87	46.9▲	#86▼
Засгийн газрын хэмжээ	70.1	#73	77.3▲	#65▼
Зохицуулалт үр ашиг	67.8	#61	68.3▲	#64▲
Зах зээлийн нээлттэй байдал	58.1	#89	58.1●	#87▼
Нэгдсэн индекс	60.6	#76	62.6▲	#74▼

Манай улсын хувьд 2025 онд Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр 62.6 оноо авсан нь өмнөх оноос 2.0 оноогоор, дэлхийн дундаж 59.7 онооноос 2.9 оноогоор илүү байна. Индексийн үнэлгээ нэмэгдэхэд 2023 он (Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн 2025 оны үр дүн нь 2023 оны тоо, мэдээлэлд суурилж тооцогдсон)-д Засгийн газрын зарлага буурч, төсвийн сахилга бат сайжирсан нь голчлон нөлөөллөө. Түүнчлэн, Татварын дарамт 9 байр, Хөрөнгө оруулалтын эрх чөлөө 10 байр, Санхүүгийн эрх чөлөө, Хөдөлмөрлөх эрх чөлөө гэсэн дэд бүлэг тус тус 4 байр ахижээ. Үүнд уул уурхайн салбарын

өсөлтийг дагаж худалдааны эргэлт нэмэгдсэн, эдийн засгийн үзүүлэлтүүд, төсвийн сахилга бат сайжирсан зэрэг нь манай улсын үнэлгээг шууд сайжруулахын зэрэгцээ хөрөнгө оруулалт, санхүү, хөдөлмөрлөх эрх чөлөөний үзүүлэлтүүдийн үнэлгээг мөн ахиулсан байна.

Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийг тооцохдоо нийт 12 дэд бүлэг⁹ үзүүлэлтийг ижил жингээр үнэлж тооцдог. Эдгээр бүлэг үзүүлэлтийн зарим нь зөвхөн ганц тоон үзүүлэлтээр хэмжигдэх бол зарим нь чанарын олон үзүүлэлтээр хэмжигдэх бөгөөд дахин өөр индексүүдийг дотроо агуулсан байх нь ч бий.

Иймд хамгийн цөөн дэд үзүүлэлт бүхий бүлэг индексийн үнэлгээнд хамгийн их нөлөө үзүүлдэг. Энэ дагуу дэд үзүүлэлтүүдийг шүүж үзвэл засгийн газрын зарлага, төсвийн алдагдал, инфляцын түвшин гэсэн 3 үзүүлэлт индексийн үнэлгээний 20 гаруй хувийг бүрдүүлж байна. Тиймээс эдгээр үзүүлэлтийг сайжруулснаар Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн үнэлгээг хамгийн хялбараар сайжруулах боломжтой юм.

Засгийн газрын зарлага: Уг үзүүлэлт нь ДНБ-д харьцуулсан засгийн газрын зарлагын сүүлийн гурван жилийн дунджаар хэмжигддэг бөгөөд бага байх тусам өндөр үнэлгээ авдаг. Монгол Улсын хувьд 2021-2023 онд энэ үзүүлэлт буурсан нь 2025 оны индексийн үнэлгээ ахих гол хүчин зүйл болсон. Цаашид уг үзүүлэлтийг тогтвортой бууруулж, ДНБ-ий 30 хувьд хүргэснээр бусад үзүүлэлтүүд болон бусад улсуудын урагшлах хандлага ижил түвшинд хадгалагдана гэж үзвэл зөвхөн засгийн газрын зарлагын үзүүлэлтээр Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс дэх

⁷ The Heritage Foundation

⁸ Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийг улс орнуудын Хууль дээдлэх ёс, Засгийн газрын хэмжээ, Зохицуулалтын үр ашигтай байдал болон Зах зээлийн нээлттэй байдал гэсэн 4 бүлэг, 12 дэд бүлгийн хүрээнд нэгтгэн тооцдог байна. Нийт 0-100 онооны хооронд үнэлдэг бөгөөд индекс 100-д ойртох тусам эдийн засгийн эрх чөлөөт байдал өндөр, 0-д дөхөх тусам эдийн засгийн эрх чөлөөт байдал сул гэж үздэг.

⁹ Өмчийн эрх, Шүүхийн үр ашиг, Төрийн зарчимт байдал, Татварын дарамт, Засгийн газрын зарлага, Төсвийн сахилга бат, Бизнесийн эрх чөлөө, Хөдөлмөрлөх эрх чөлөө, Мөнгөний эрх чөлөө, Худалдааны эрх чөлөө, Хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал, Санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал гэсэн дэд бүлэг үзүүлэлтүүдтэй ба 0-100 онооны хооронд үнэлэн оноог дунджилж нийт индексийг тооцдог.

манай улсын эрэмбийг 1-2 байраар урагшлуулах боломжтой (Зураг 5.1-1).

Төсвийн алдагдал: Төсвийн сахилга бат бүлгийг ДНБ-д харьцуулсан төсвийн алдагдлын хэмжээ болон засгийн газрын өрийн хэмжээгээр 80 болон 20 хувийн жин өгч дундажлан тооцдог. Төсвийн тэнцэл ДНБ-д эзлэх хэмжээгээрээ ашигтай байх тусам энэхүү үзүүлэлт өндөр үнэлгээ авдаг. Монгол Улсын хувьд 2021-2023 оны хугацаанд уг үзүүлэлт сайжирсан нь 2025 оны индексийн үнэлгээ нэмэгдэхэд эергээр нөлөөлсөн. Цаашид ч төсвийн тэнцлийг алдагдалгүй байлгах бодлого баримталж байна (Зураг 5.1-2).

Инфляцын түвшин: Индекс дэх Мөнгөний эрх чөлөөний бүлгийг тооцохдоо инфляцын сүүлийн гурван жилийн дунжийг ашиглан тооцдог. Манай улсын хувьд 2021-2023 онд инфляцын дундаж түвшин 11 хувьд хүрсэн нь тус бүлэг үзүүлэлтээр хойгуур жагсахад хүргэсэн байдаг. Харин энэ үзүүлэлтээр дундуур байр эзэлж буй улс орнуудын инфляцын түвшин 4 хувь орчимд хэлбэлзэж байна. Иймд инфляцын дундаж түвшнийг бууруулж 4-5 хувьд хүргэснээр Мөнгөний эрх чөлөөний үзүүлэлтийг сайжруулах боломжтой байна (Зураг 5.1-3).

Олон улсын түвшинд авч үзвэл цар тахлын нөлөөгөөр 2024 онд 2001 оноос хойших хамгийн


доод түвшинд хүрээд байсан Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн дэлхийн дундаж оноо 2025 онд 1.1 хувиар өсөж 59.7 болж сэргэв. Гэвч цар тахлын дараах санхүүгийн сорилтууд олон улсад төсвийн сахилга батад сөргөөр нөлөөлсөн хэвээр байна. Өндөр төсвийн алдагдал, хуримтлагдсан өр нь бүтээмжийн өсөлтийг сааруулж, эдийн засгийн тогтвортой сэргэлтийг хязгаарлах хүчин зүйлс болж байна гэж дүгнэжээ.

Эдийн засгийн эрх чөлөөт байдлаар Европын Холбооны улсууд болон Сингапур Улс тэргүүлэгч байр сууриа хадгалсаар байна. Европын Холбооны улсуудад төрийн үйл ажиллагааны ил тод байдал өндөр хөгжсөн бол Сингапур Улсад өмчийн эрхийн хамгаалал, авлигын эсрэг хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлж, ил тод өрсөлдөөнийг дэмжсэн зохицуулалт, бизнес эхлүүлэх үйл явц нь энгийн, хялбар байдаг байна. Харин эрэмбийн төгсгөлд Хойд Солонгос, Куб, Венесуэл, Зимбабве, Судан улсууд бичигджээ.

Зураг 5.33. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс

1.Засгийн газрын зарлагын ДНБ-д эзлэх хувь, 3 жилийн дундаж


(хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Сангийн яамны статистик

2.Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь, 3 жилийн дундаж


(хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Сангийн яамны статистик

3.Инфляцын түвшин, 3 жилийн дундаж

(хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик

97. Эдийн засгийн цогц байдлын индекс:

Харвардын өсөлтийн лабораториос жил бүр тооцоолон гаргадаг Эдийн засгийн цогц байдлын индекс¹⁰ (Economic complexity index)-ээр Монгол Улс 2023 онд үнэлгээнд хамрагдсан 145 улсаас 137 дугаарт эрэмбэлэгдэж өмнөх оноос (2022) 2 байр урагшилсан байна. Гэсэн хэдий ч энэ нь 10 жилийн өмнөх (2013)-өөс 2, 5 жилийн өмнөх (2018)-өөс 5 байраар ухарсан үзүүлэлт юм.

Монгол Улсын сүүлийн 10 жилийн эрэмбийг (Зураг 5.2)-т харвал хамгийн бага эдийн засгийн цогц байдлын индекстэй улсуудын бүлэг (10 дугаар децилд)-т орсон байна.

Зураг 5.4 Эдийн засгийн цогц байдлын индекс дэх Монгол Улсын эрэмбэ, 2013-2023 он



Эх сурвалж: Харвардын өсөлтийн лаборатори

Эдийн засгийн цогц байдлын индекс нь улс орны экспортын төрөлжилт болон экспортолж буй бүтээгдэхүүнд хэр мэдлэг шингэсэн байдлыг хэмждэг. Түүхий эд хэлбэрээр экспортолж буй бүтээгдэхүүн нь мэдлэг бага шингэсэн бүтээгдэхүүнд тооцогдох бол технологи, инновац ашигласан бүтээгдэхүүн нь илүү мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн болдог. Харин экспортын төрөлжилт нь улс орон хэдэн бүтээгдэхүүний

хувьд харьцангуй давуу талтай¹¹ гэдгээр илэрхийлэгддэг.

Монгол Улс 2023 оны байдлаар 406 бүтээгдэхүүн экспортолж байгаагаас 40 бүтээгдэхүүн нь харьцангуй давуу талтай, үүнээс 9 бүтээгдэхүүн нь мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн байна. Эдгээр 40 бүтээгдэхүүний дийлэнх нь хөдөө аж ахуй болон уул уурхайн бүтээгдэхүүн буюу түүхий эд голдуу бүтээгдэхүүн зонхилж байна. Энэ нь Монгол Улсад экспортын төрөлжилт сул, технологи болон инновац шингээсэн бүтээгдэхүүн бага байгааг илтгэж байна.

Харин индекс өндөр улс орнууд электрон хэрэгсэл, машин механизм, химийн бодис зэрэг мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн түлхүү экспортолж байна. Жишээлбэл, 3 дугаар байранд эрэмбэлэгдсэн Япон Улс 323 харьцангуй давуу талтай бүтээгдэхүүнтэй, үүнээс 272 нь мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн байна.

¹⁰ Эдийн засгийн цогц байдлын индекс нь улс орнуудын экспортолж буй бүтээгдэхүүнийг энгийн бүтээгдэхүүн болон мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн гэж ангилан оноожуулж тухайн орны үйлдвэрлэлийн мэдлэгийн түвшнийг хэмждэг. Индекс -3-аас +3-ын хооронд утга авах бөгөөд 3-д дөхөх тусам эдийн засгийн цогц байдал өндөр, -3-д дөхөх тусам сул байгааг илэрхийлдэг.

¹¹ Харьцангуй давуу талтай бүтээгдэхүүний тоог тооцохдоо тухайн улсын экспортын бүтэц дэлхийн экспортын бүтэцтэй хэр ойролцоо байгаагаар хэмждэг буюу тухайн бүтээгдэхүүний улсын нийт экспортод эзлэх хувь нь уг бүтээгдэхүүний дэлхийн нийт экспортод эзлэх хувиас их бол тэр улс уг бүтээгдэхүүний хувьд харьцангуй давуу талтай гэж үздэг.

98. Хүний хөгжлийн индекс:

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс жил бүр тооцоолон гаргадаг Хүний хөгжлийн индексээр¹² Монгол Улс 2025 онд үнэлгээнд хамрагдсан 193 улсаас 104 дүгээрт эрэмбэлэгдэж 1 байр ахилаа.

Ингэснээр Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтэд Хүний хөгжлийн индексээр 2025 онд нэг байр ахих зорилтот түвшинд хүрсэн байна.

Монгол Улсын үнэлгээг индексийн үзүүлэлт тус бүрээр доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5. Хүний хөгжлийн индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ

Дэд үзүүлэлт	2024		2025	
	Үзүүлэлт	Байр	Үзүүлэлт	Байр
Дундаж наслалт /жил/	71.5	#117	71.7▲	#116▼
Насанд хүрэгчдийн нийт суралцсан дундаж хугацаа /жил/	9.4	#105	9.4●	#105●
Сургуульд орох насны хүүхдийн цаашид сургуульд суралцах дундаж хугацаа /жил/	13.6	#93	13.6●	#95▲
Нэг хүнд ногдох ҮНО (2021 PPP \$)	13,683	#105	14,787▲	#100▼
Хүний хөгжлийн индекс	0.742	#105	0.747▲	#104▼

Дэд үзүүлэлтээр задлан харвал Монгол Улсын дундаж наслалт 2025 оны үнэлгээгээр (2023 оны тоон мэдээллийг ашигласан) өмнөх оноос 0.2 жилээр, нэг хүнд ногдох ҮНО 1,004 ам.доллараар (2021 PPP) нэмэгдсэнээр Хүний хөгжлийн индекс өмнөх оноос 0.005 оноогоор сайжирч 0.747 болсон байна.

Улс орнуудыг Хүний хөгжлийн түвшнээр маш өндөр, өндөр, дундаж, муу гэж ангилж байна. 2025 онд хүний хөгжлийн маш өндөр түвшинтэй буюу 0.800-аас илүү үнэлгээ авсан 74 улс, өндөр буюу 0.700-0.799 хооронд үнэлэгдсэн 50 улс, дундаж буюу 0.550-0.699 хооронд үнэлэгдсэн 43 улс, муу буюу 0.550-аас бага үнэлгээ авсан 26 улс байна. Манай улс 0.747 оноогоор хүний хөгжил өндөр гэсэн ангилалд орж байгаа боловч уг үнэлгээ нь дэлхийн дундаж болох 0.756 оноонд хүрэхгүй байна. Дэлхийн дундажтай харьцуулахад Монгол Улсад сургуульд суралцах хугацаа өндөр байгаа боловч дундаж наслалт 1.7 жилээр, нэг хүнд ногдох ҮНО 5,540 ам.доллараар (2021 PPP) бага байна.

Дэлхийд хүний хөгжлөөр Исланд, Норвег, Швейцар, Дани, Герман, Швед зэрэг улс тэргүүлж, дунджаар 0.965 үнэлгээ авсан байна. Харин Өмнөд Судан, Сомали, Чад, Нигер, Мали зэрэг улс хүний хөгжлөөр хамгийн сул буюу дунджаар 0.410 оноо авчээ. Мөн Хүний хөгжлийн индекс ЭЗХАХБ (OECD)¹³-ын улс орнуудад 0.916, хөгжиж буй улс орнуудад дунджаар 0.712, хөгжил буурай орнуудад 0.560 байна.

2024 онд тус индексийн аргачлалд өөрчлөлт орж, нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын хэмжээг тооцоолохдоо суурь үнийг 2017 оноос 2021 он болгон өөрчилсөн. Түүнчлэн Монгол Улсын дундаж наслалтыг 2024 онд 72.4 гэж оруулсан байсныг засварлаж 71.5 болгосон байна. Үүний улмаас Монгол Улсын 2022 оны үнэлгээ дахин тооцогдож, 96 дугаарт эрэмбэлэгдсэн байсан бол 105 дугаар байр болж өөрчлөгджээ.

¹² Хүний хөгжлийн индекс нь хүний чадавхын хөгжлийг харуулах бөгөөд эрүүл саруул байж, урт удаан наслах, эрдэм мэдлэг эзэмших, амьжиргааны зохистой нөхцөлд аж төрөх гэсэн хүний амьдралын үндсэн гурван хэмжигдэхүүнийг илэрхийлнэ. Үүнд, 1/ Эрүүл мэнд (Хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалт), 2/ Боловсрол (Насанд хүрэгчдийн нийт суралцсан дундаж хугацаа болон сургуульд орох насны хүүхдийн цаашид сургуульд

суралцах дундаж хугацааны геометр дундаж), 3/ Амьжиргааны түвшин (Нэг хүнд ногдох ҮНО (PPP-д суурилсан, засвар оруулсан утга). Хүний хөгжлийн индекс нь дээрх 3 үзүүлэлтийн геометр дундаж юм. Индекс 0-1-ийн хооронд утга авах бөгөөд 1-д дөхөх тусам хүний хөгжил өндөр, 0-д дөхөх тусам хүний хөгжил сул байгааг илэрхийлдэг.

¹³ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

Хавсралт

Хүснэгт 6. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2023 Q1	2023 Q2	2023Q3	2023Q4	2024 Q1	2024 Q2	2024 Q3	2024 Q4	2025 Q1
БОДИТ СЕКТОР									
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөгөөр)	13,971	30,980	47,388	70,442	16,465	36,792	55,072	79,956	18,968
Бодит ДНБ өсөлт - үйлдвэрлэл (хувиар)	8.0	6.7	7.2	7.4	7.9	5.6	5.0	4.9	2.4
Бодит ДНБ өсөлт - эцсийн ашиглалт (хувиар)	7.9	6.3	7.2	7.2	8.0	5.7	4.9	5.0	2.4
Дотоод эрэлтийн оролцоо (нэгж хувиар)	-2.5	-7.1	-1.5	5.4	32.5	27.7	25.7	21.4	17.4
Бараа, үйлчилгээний экспортын оролцоо (нэгж хувиар)	44.4	37.1	27.7	18.0	-7.2	-1.5	-2.1	0.5	-11.6
Бараа, үйлчилгээний импортын оролцоо (нэгж хувиар)	-34.0	-23.7	-19.0	-16.2	-17.3	-20.5	-18.8	-16.8	-3.3
Бодит ДНБ-ий өсөлт дэх оролцоо (нэгж хувиар)									
Эцсийн хэрэглээ	4.1	7.7	9.7	7.0	18.9	18.1	14.0	12.1	8.4
Өрхийн хэрэглээ	2.0	4.7	6.3	6.3	12.7	12.1	10.0	8.6	9.6
Төрийн байгууллагын хэрэглээ	2.0	3.1	3.3	0.7	6.2	6.0	4.1	3.6	-1.2
Хөрөнгийн нийт хуримтлал	-6.6	-14.9	-11.2	-1.6	13.5	9.6	11.7	9.3	9.0
Цэвэр экспорт	10.4	13.4	8.8	1.8	-24.5	-21.9	-20.8	-16.4	-14.9
ҮНИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД									
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны дунджаар, хувиар)	12.2	11.6	11.0	10.4	7.2	6.5	6.4	6.8	9.1
Зэсийн үнэ* (\$/тонн)	8,919	8,695	8,582	8,479	8,443	9,094	9,132	9,145	9,330
Алтын үнэ* (\$/трой. унци)	3,123	2,829	2,695	2,647	2,452	2,641	2,297	2,779	2,840
ДНБ дефлятор (хувиар)	33.4	24.4	23.1	21.8	9.2	12.5	10.7	8.2	12.5
(тэрбум төгрөгөөр)									
НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД									
Нийт орлого ба тусламжийн дүн	5,073	11,059	17,653	24,387	7,673	14,947	22,350	31,375	6,432
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	4,795	10,581	16,908	23,295	7,322	14,199	21,290	29,589	6,150
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	4,138	9,034	14,750	22,509	5,695	12,911	19,822	30,365	6,503
Нийт тэнцэл	935	2,025	2,903	1,878	1,978	2,036	2,528	1,010	-70
Нийт үндсэн тэнцэл	1,267	2,539	3,830	3,028	2,380	2,631	3,486	2,205	338
Тэнцвэржүүлсэн тэнцэл	657	1,548	2,158	786	1,627	1,287	1,469	-776	-353
МӨНГӨНИЙ СЕКТОР									
M2 мөнгөний өсөлт (хувиар)	16.8	13.8	20.9	26.8	20.9	31.9	25.9	15.2	10.9
Нөөц мөнгөний өсөлт (хувиар)	4.7	2.6	22.6	7.4	11.7	29.6	5.8	51.9	81.3
Мөнгөний эргэлтийн хурд (нэгжээр)	1.9	2.0	2.0	1.9	2.0	1.8	1.9	1.8	2.0
Мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	5.7	5.4	5.3	5.2	6.1	5.5	6.3	3.9	3.8
Зээлийн өсөлт** (хувиар)	8.4	11.5	14.0	22.7	22.3	27.3	31.3	31.0	31.2
(сая ам.доллороор)									
ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ									
Төлбөрийн тэнцэл	80	474	791	1,457	373	-57	-251	622	-602
Урсгал дансны тэнцэл	315	221	430	121	-537	-957	-1,701	-2,485	-959
ГВУН	3,438	3,818	4,124	4,921	5,250	4,839	4,663	5,510	4,996
сарын бараа, үйлчилгээний импортын хүрэлцээ	3.2	3.5	3.7	4.4	4.4	3.9	3.5	4.0	3.6
Гадаад валютын ханш									
Валютын ханш USD/MNT (дунджаар)	3,499	3,482	3,475	3,466	3,392	3,386	3,384	3,390	3,454
Валютын ханш USD/MNT (хугацааны эцсээр)	3,518	3,433	3,460	3,411	3,376	3,381	3,381	3,420	3,488
Нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	35.5	36.3	37.1	37.6	39.4	39.6	39.5	39.6	39.3
Бодит үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	101.9	106.1	109.3	111.1	117.1	118.7	118.9	120.2	126.8

*Bloomberg Terminal

**Ипотекийн зээлээр баталгаажсан бондыг оруулсан дүн

Хүснэгт 7. Бодит секторын үзүүлэлтүүд

БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2023 Q1	2023 Q2	2023Q3	2023Q4	2024 Q1	2024 Q2	2024 Q3	2024 Q4	2025 Q1 ¹
Нэрлэсэн ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	13,971	30,980	47,388	70,442	16,465	36,792	55,072	79,956	18,968
Бодит ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	5,630	13,661	21,751	30,567	6,077	14,419	22,829	32,054	6,221
(өсөлт, хувиар)									
Бодит ДНБ-ий өсөлт	8.0	6.7	7.2	7.4	7.9	5.6	5.0	4.9	2.4
Уул уурхайн	48.7	44.9	32.7	23.4	13.3	15.4	11.4	10.8	0.8
Уул уурхайн бус	3.2	3.0	4.3	5.4	7.0	4.2	4.0	4.0	2.7
Хөдөө аж ахуй	-5.1	-9.9	-9.5	-8.9	-24.8	-26.7	-25.0	-28.7	35.6
Уул уурхай	48.7	44.9	32.7	23.4	13.3	15.4	11.4	10.8	0.8
Боловсруулах аж үйлдвэр	-6.8	1.6	3.9	5.1	4.9	6.3	0.1	-1.2	3.7
Цахилгаан дулаан	4.0	4.7	5.1	5.0	7.7	5.3	5.2	4.8	5.5
Барилга	1.2	3.2	4.1	3.1	27.7	19.5	7.8	10.4	-1.1
Бөөний болон жижиглэн худалдаа	10.0	7.4	7.0	6.8	6.0	6.8	7.9	6.6	-5.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	76.6	74.3	58.6	39.6	26.9	24.7	15.7	23.1	-21.6
Мэдээлэл, холбоо	5.4	11.9	16.9	17.0	27.5	17.4	14.4	15.5	16.5
Бусад үйл ажиллагаа	1.6	2.3	3.3	5.8	3.4	7.1	8.6	7.8	7.1
Цэвэр татвар	-3.7	2.4	4.1	6.6	13.1	15.0	14.6	16.1	-2.3
Дефлятор	33.4	24.4	23.1	21.8	9.2	12.5	10.7	8.2	12.5
(нэгж хувиар)									
ДНБ-ий өсөлт дэх салбаруудын оролцоо									
Хөдөө аж ахуй	-0.2	-1.7	-1.6	-1.3	-1.0	-3.9	-3.5	-3.6	1.0
Уул уурхай	5.1	3.9	3.3	2.6	1.9	1.8	1.4	1.4	0.1
Боловсруулах аж үйлдвэр	-0.5	0.1	0.3	0.4	0.3	0.4	0.0	-0.1	0.2
Цахилгаан дулаан	0.2	0.1	0.1	0.1	0.3	0.2	0.1	0.1	0.2
Барилга	0.0	0.0	0.1	0.1	0.2	0.3	0.1	0.3	0.0
Бөөний болон жижиглэн худалдаа	1.1	0.8	0.8	0.8	0.7	0.7	0.9	0.7	-0.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2.2	1.9	2.2	1.8	1.3	1.0	0.9	1.3	-1.2
Мэдээлэл, холбоо	0.2	0.4	0.5	0.5	0.9	0.6	0.5	0.5	0.6
Бусад үйл ажиллагаа	0.6	0.7	1.0	1.7	1.2	2.1	2.4	2.2	2.4
Цэвэр татвар	-0.7	0.4	0.6	0.8	2.1	2.3	2.1	2.0	-0.4
(тэрбум төгрөгөөр)									
Нэрлэсэн ДНБ (эцсийн ашиглалтын аргаар)	14,695	30,540	48,503	71,202	17,080	37,212	56,702	80,049	19,045
Анхдагч орлого	-1,520	-3,566	-5,344	-7,738	-2,054	-4,913	-7,395	-9,054	-1,920
Үндэсний нийт орлого	13,175	26,974	43,158	63,463	15,025	32,299	49,306	70,994	17,126
Хоёрдогч орлого	476	623	1,176	1,378	571	824	1,406	1,428	488
Үндэсний нийт цэвэр орлого	13,651	27,597	44,334	64,841	15,596	33,123	50,713	72,422	17,613
Нийт дотоод эрэлт	12,542	26,812	42,828	64,404	16,704	35,232	55,854	80,540	20,908
Үндэсний хадгаламж	4,614	8,847	15,264	24,317	3,618	7,876	12,299	19,582	3,315
Хөрөнгийн нийт хуримтлал	3,506	8,062	13,758	23,880	4,727	9,985	17,440	27,700	6,609

Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд

НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2023 Q1	2023 Q2	2023Q3	2023Q4	2024 Q1	2024 Q2	2024 Q3	2024 Q4	2025 Q1 ¹
(тэрбум төгрөгөөр)									
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,073	11,059	17,653	24,387	7,673	14,947	22,350	31,375	6,432
Ирээдүйн өв сан	0	0	161	416	284	528	694	841	209
Тогтворжуулалтын сан	278	478	585	676	67	221	366	444	74
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,795	10,581	16,908	23,295	7,322	14,199	21,290	29,589	6,150
Татварын орлого	4,535	9,841	15,819	21,484	6,909	13,291	19,952	27,377	5,795
Орлогын албан татвар	1,431	2,552	4,346	5,703	2,557	4,266	6,402	8,981	2,017
Нийгмийн даатгалын орлого	833	1,795	2,744	3,951	920	2,105	3,322	4,700	1,185
Хөрөнгийн албан татвар	63	199	292	395	109	240	335	460	141
Нэмэгдсэн өртгийн албан татвар	982	2,182	3,399	4,777	1,286	2,777	4,313	5,864	1,250
Онцгой албан татвар	166	374	593	790	280	515	819	1,098	295
Тусгай зориулалтын орлого	5	10	16	22	6	13	19	26	7
Гаалийн албан татвар	314	686	1,063	1,465	352	813	1,315	1,792	394
Бусад татвар,төлбөр, хураамж	741	2,044	3,366	4,382	1,398	2,561	3,426	4,455	506
Татварын бус орлого	260	740	1,089	1,811	413	908	1,338	2,212	354
Нийтлэг татварын бус орлого	228	620	898	1,452	339	717	1,036	1,770	327
Хөрөнгийн орлого	1	1	4	8	1	2	5	7	1
Тусламжийн орлого	31	119	188	351	73	188	297	435	26
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,138	9,034	14,750	22,509	5,695	12,911	19,822	30,365	6,503
Урсгал зарлага	3,670	7,557	11,820	17,091	4,698	10,376	15,551	22,067	5,900
Цалин, хөлс	457	951	1,547	2,327	1,081	2,585	3,706	5,363	1,511
Бараа, үйлчилгээний бусад зардал	482	1,093	1,611	2,758	687	1,660	2,432	4,082	720
Татаас	122	266	382	580	134	367	649	955	243
Урсгал шилжүүлэг	2,277	4,732	7,353	10,276	2,394	5,170	7,807	10,472	3,017
Зээлийн үйлчилгээний төлбөр	333	514	926	1,150	402	595	958	1,195	408
Гадаад	306	460	855	1,054	395	582	943	1,146	407
Дотоод	26	54	71	96	6	13	15	49	1
Хөрөнгийн зардал ба цэвэр зээл	468	1,477	2,930	5,418	997	2,535	4,271	8,299	602
Хөрөнгийн зардал	488	1,444	2,827	5,188	843	2,296	3,967	7,924	592
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-20	33	103	229	154	239	304	374	10
НИЙТ ТЭНЦЭЛ	935	2,025	2,903	1,878	1,978	2,036	2,528	1,010	-70
ҮНДСЭН ТЭНЦЭЛ	1,267	2,539	3,830	3,028	2,380	2,631	3,486	2,205	338
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	657	1,548	2,158	786	1,627	1,287	1,469	-776	-353
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-657	-1,548	-2,158	-786	-1,627	-1,287	-1,469	776	353
Гадаад	944	111	28	1,041	-67	-72	-197	3,414	76
ЗГ-ын бонд*	1,009	-262	-262	97	-573	-573	-573	2,623	300
ЗГ-ын зээл*	-65	374	290	944	506	501	376	791	-224
Дотоод	-1,601	-1,659	-2,186	-1,827	-1,560	-1,216	-1,272	-2,637	277
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-1,402	-1,276	-1,687	-1,028	-1,530	-1,123	-1,134	-3,001	277
ЗГ-ын бонд*	-199	-384	-501	-801	-30	-93	-138	363	0
ЗГ-ын зээл*	0	0	0	0	0	0	0	0	0
Өмч хувьчлал	0.37	0.59	2.48	2.55	0.04	0.11	0.11	0.84	0.03
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0	0	0	0	0	0	0	0	0
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад	0	0	0	0	0	0	0	0	0

*Цэвэр дүн

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2023 Q1	2023 Q2	2023Q3	2023Q4	2024 Q1	2024 Q2	2024 Q3	2024 Q4	2025 Q1
(сая ам.доллараар)									
I. УРСГАЛ ДАНС	315	221	430	121	-537	-957	-1,701	-2,485	-959
Бараа	1,403	2,441	3,498	4,549	945	1,942	2,364	3,081	333
Экспорт Ф.О.Б (кредит)	3,349	6,738	10,316	13,914	3,431	7,443	11,064	14,750	2,852
Импорт Ф.О.Б (дебит)	1,945	4,298	6,817	9,366	2,486	5,501	8,700	11,668	2,520
Үйлчилгээ	-790	-1,374	-1,869	-2,592	-1,044	-1,692	-2,295	-3,317	-876
Кредит	240	640	1,204	1,587	272	627	1,225	1,604	318
Дебит	1,030	2,014	3,072	4,179	1,317	2,319	3,520	4,922	1,194
Анхдагч орлого	-434	-1,024	-1,538	-2,233	-606	-1,451	-2,185	-2,671	-556
Кредит	96	216	330	455	130	272	416	559	142
Дебит	531	1,240	1,868	2,687	735	1,723	2,601	3,230	698
Хоёрдогч орлого	136	179	338	398	168	243	416	421	141
II. ХӨРӨНГИЙН ДАНС	22	60	89	135	32	78	120	171	20
Кредит	22	63	95	149	36	87	130	183	21
Дебит	1	3	6	14	4	9	10	12	1
III. САНХҮҮГИЙН ДАНС: (зээлдүүлэг+/зээллэг-)	501	-58	-189	-1,477	-752	-921	-1,107	-3,330	-595
Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	-308	-848	-1,393	-2,172	-674	-1,632	-2,047	-2,727	-431
Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	-173	101	331	818	-7	-206	-220	-1,105	-76
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (цэвэр)	0	-1	-1	-2	8	0	-8	-13	8
Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	982	690	875	-121	-79	917	1,168	515	-96
Үүнээс: Бэлэн мөнгө ба харилцах	474	135	345	354	-229	840	1,095	1,075	-131
Зээл	80	-133	-117	-529	-89	-48	-187	-630	-133
Худалдааны зээл	428	688	647	54	239	125	260	70	168
IV. Алдаа болон орхигдуулга	243	134	84	-276	126	-99	223	-393	-258
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	80	474	791	1,457	373	-57	-251	622	-602
V. Нөөц хөрөнгө	80	474	791	1,457	373	-57	-251	622	-602
ГВУН	77	456	760	1,398	359	-96	-307	540	-616
ОУВС-гийн зээл	-2	-17	-32	-59	-14	-38	-56	-82	-14
Тусгай санхүүжилт	0	0	0	0	0	0	0	0	0
Нэмэлт үзүүлэлтүүд:									
Нэрлэсэн ДНБ (сая ам.доллараар)	3,992	8,898	13,637	20,325	4,854	10,866	16,273	23,585	5,492
Гадаад валютын албан нөөц (сая ам.доллараар)	3,438	3,818	4,124	4,921	5,250	4,839	4,663	5,510	4,996
Гадаад валютын албан нөөц (сарын импортоор)	3.2	3.5	3.7	4.4	4.4	3.9	3.5	4.0	3.6
Валютын ханш MNT/USD (дунджаар)	3,499	3,482	3,475	3,466	3,392	3,386	3,384	3,390	3,454
Валютын ханш MNT/USD (хугацааны эцсээр)	3,518	3,433	3,460	3,411	3,376	3,381	3,381	3,420	3,488

МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2023 Q1	2023 Q2	2023Q3	2023Q4	2024 Q1	2024 Q2	2024 Q3	2024 Q4	2025 Q1
(тэрбум төгрөгөөр)									
Гадаад цэвэр актив	3,935	3,998	6,607	8,959	9,775	9,865	8,437	8,704	5,282
Дотоод цэвэр актив	27,004	27,450	26,604	28,665	27,625	31,603	33,366	34,630	36,202
Дотоодын цэвэр зээл	25,335	26,874	26,600	29,106	28,477	32,296	34,091	35,343	37,667
Бусад цэвэр зүйлс	1,669	576	4	-441	-852	-694	-726	-714	-1,466
M2 мөнгө	30,939	31,448	33,211	37,624	37,400	41,467	41,803	43,334	41,483
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	767	822	838	906	827	1,040	961	978	916
Харилцах болон хадгаламж	30,171	30,626	32,373	36,719	36,573	40,428	40,841	42,356	40,568
(өсөлт, хувиар)									
Жилийн өсөлт									
M2 мөнгө	16.8	13.8	20.9	26.8	20.9	31.9	25.9	15.2	10.9
Гадаад цэвэр актив	222.7	436.9	740.4	259.6	148.4	146.7	27.7	-2.8	-46.0
Дотоод цэвэр актив	6.9	2.1	-0.3	5.5	2.3	15.1	25.4	20.8	31.0
Дотоодын цэвэр зээл	-0.5	0.3	1.6	13.5	12.4	20.2	28.2	21.4	32.3
ЗГ-аас авах авлага	171.3	216.7	152.0	91.3	57.9	53.9	30.1	64.2	13.4
Бусад салбараас авах авлага	8.7	10.6	12.3	19.8	18.5	24.8	28.5	27.0	28.9
Улсын байгууллагаас авах авлага	-5.9	-13.5	-13.4	-16.7	-8.6	13.2	0.2	13.1	4.6
Хувийн сектороос авах авлага	9.5	11.8	13.6	21.7	19.8	25.2	29.6	27.5	29.9
(нэгж хувиар)									
M2 мөнгөний өсөлт дэх оролцоо									
M2 мөнгө	16.8	13.8	20.9	26.8	20.9	31.9	25.9	15.2	10.9
Гадаад цэвэр актив	10.3	11.8	21.2	21.8	18.9	18.7	5.5	-0.7	-12.0
Дотоод цэвэр актив	6.6	2.0	-0.3	5.0	2.0	13.2	20.4	15.9	22.9
Нэмэлт үзүүлэлтүүд:									
Мөнгөний эргэлтийн хурд	1.9	2.0	2.0	1.9	2.0	1.8	1.9	1.8	2.0
Нэрлэсэн ДНБ-ий өсөлт (хувиар)	44.1	32.7	32.0	30.8	17.9	18.8	16.2	13.5	15.2
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцсээр, хувиар)	12.2	11.6	11.0	10.4	7.2	6.5	6.4	6.8	9.1